

ТӨЛБӨРТЭЙ ДАВТЛАГА/ ДАМЖАА

Судалгааны тайлан

Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

*Будапештийн Боловсролыг Дэмжих Хөтөлбөр
All rights reserved*

©2005

Судалгааны баг

Аюуш БАТЖАРГАЛ

Мэдээлэл холбооны технологийн
Ерөнхий захирал

Нацагдорж ЭНХТУЯА

Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
Гүйцэтгэх захирал

Цэцгээ БОЛОРМАА

Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
Менежер

Сэнгэдорж ТҮМЭНДЭЛГЭР

Монгол Улсын Боловсролын Их Сургууль
Түүх Нийгмийн Ухааны Сургуулийн социологч, судлаач

АЛИСОН Донг

Багшийн Коллеж
Колумбын Их Сургууль, АНУ

ХУРААНГУЙ

Монгол улс Будапешт дэх Нээлттэй Нийгмийн хүрээлэнгээс санаачлан хэрэгжүүлж байгаа Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын хамрагдаж буй төлбөрт давтлага/дамжааны талаарх олон улсын судалгаанд оролцож байгаа нь энэ асуудлаар хийж байгаа анхны томоохон ажил боллоо.

Төлбөртэй давтлага/дамжаа судалгааг Монголын Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс эрхлэн зохион байгуулав.

Монголын Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс төлбөртэй давтлага/дамжаа судалгааг явуулах ажлын хэсгийг сонгон томилж ажиллуулсан бөгөөд Будапешт дэх Нээлттэй Нийгмийн хүрээлэнгээс боловсруулсан судалгааны асуулгыг баримтлан өөрийн орны нөхцөлд тохируулан боловсруулж судалгааг явуулав.

Судалгааны ажлын хэсэг Монгол дахь төлбөртэй давтлага/дамжааны цар хүрээ, шалтгаан, үр дагаврыг судлан үзэж судалгааны үр дүнг БСШУЯ болон бодлого боловсруулагчдад танилцуулах замаар ЕБС-иудын сургалтын чанарыг дээшлүүлэхэд нөлөөлөх бусад улсуудад хийсэн судалгаатай харьцуулан дүгнэлт гаргах зорилт тавин ажилласан болно.

Судалгааны материалд боловсруулалт хийж байх явцад төлбөртэй давтлага/дамжааны асуудал нь дэлхийн олон оронд байдгийн нэг адил асар том нуугдмал үйлдвэрлэл болтлоо өргөжсөнөөс гадна багшийн ёс зүй алдагдах, авилгалд өртөх үндэс суурь болж, нийгмийн сэтгэл зүйд хор хөнөөл учруулж болзошгүй нь харагдлаа.

Төлбөртэй давтлага/дамжаанд судалгаанд хамрагдсан оюутнуудын 70,7 хувь нь хамрагдаж хамгийн багадаа боловсролын төсвийн урсгал зардлын 3,1-3,7 хувьтай тэнцэхүйц хэмжээний төлбөрийг багш нарт төлсөн байна.

Судалгаанд оролцогчдын олонхийн үнэлгээгээр ЕБС-ийн сургалтын чанар ихээхэн муудаж, сургалтын хөтөлбөрт заагдсан зүйлийг сурагчдад эзэмшүүлэх талаар хангалтгүй ажиллаж иржээ.

Төлбөртэй давтлага/дамжаагүйгээр сурагчдын эзэмшиж болох зүйлийг ч гэсэн эзэмшүүлэхгүй байгаа талаар судалгаанд оролцогчид шүүмжилсэн байна.

Хичээл заадаг багш нар сурлагаар хоцрогдож байгаа сурагчиддаа хандан төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдахыг санал болгох явдал түгээмэл байгааг судалгааны үр дүнгээс харж болно.

Эцэг, эхийн амжиргааны түвшин төлбөртэй давтлагад төлж буй төлбөрийн хэмжээнд нөлөөлөх болсон нь судалгаанаас харагдаж байна.

Төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдахгүй л бол их, дээд сургуульд элсэх боломжгүй гэсэн сэтгэгдэл суралцагчдад бий болсон нь дунд сургуулийн багшийн нэр хүнд ихээхэн буурч байгааг харуулав.

Иймд зөвхөн эцэг, эх, суралцагчдын сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдаж байгаа төлбөртэй давтлагаас бусад төлбөртэй давтлага/дамжаатай холбоотой асуудлуудыг хориглосон шийдвэрийг БСШУЯ-наас гаргах нь зүйтэй гэж үзэж байна.

Төлбөртэй давтлага/дамжаа бий болох үндэс суурь болсон ерөнхий боловсролын сургууль төгсөх шалгалт, их, дээд сургууль, коллежийн элсэлтийн шалгалтын талаар баримтлах бодлого чиглэлийг судалгааны үндсэн дээр тогтоон хэрэгжүүлэх шаардлага боловсролын салбарын өмнө тулгамдсан асуудлуудын нэг болсон байна.

Түүнчлэн цаашид төлбөртэй давтлага/дамжааны эерэг сөрөг талыг нарийвлан судлах шаардлагатай нь судалгаанаас харагдлаа.

Судалгаа хийхэд туслалцаа дэмжлэг үзүүлж байсан их, дээд сургуулийн удирдлага, судалгаанд оролцож өөрсдийн бодол саналаа илэн далангүй илэрхийлсэн оюутан сурагчиддаа талархсанаа илэрхийлье.

АГУУЛГА

1.	Танилцуулга	5-7
1.1.	Судалгааны үндсэн асуудлууд, судлах хэрэгцээ шаардлага	5
1.2.	Судалгааны зорилго, зорилтууд	5
1.3.	Судалгааны хамрах хүрээг тогтоох түүвэр хийхэд баримталсан арга зүй, өгөгдөл боловсруулалт	5-6
1.4.	Судалгааны хязгаарлалт	7
2.	Төлбөрт давтлагын өнөөгийн байдал	7
2.1.	Төлбөрт давтлага/дамжаа бий болсон нөхцөл байдал	7-9
2.2.	“Төлбөртэй давтлага/дамжаа” судалгааны үр дүн	9-10
2.2.1.	“Төлбөртэй давтлага” судалгааны үр дүн	10-14
2.2.2.	“Төлбөртэй дамжаа” судалгааны үр дүн	14-16
2.2.3.	“Танай ангийнхан” судалгааны үр дүн	17
2.2.4.	“Төлбөртэй давтлага, дамжааны талаарх таны бодол” судалгааны үр дүн	17-19
2.2.5.	Төлбөртэй давтлага, төлбөртэй дамжааны талаарх судалгаанд оролцогчдын санал бодолд хийсэн харьцуулалт	19-20
2.2.6.	Төлбөртэй давтлага, төлбөртэй дамжаа ба боловсрол дахь сүүдрийн эдийн засаг	20-21
3.	Дүгнэлт	22-24
4.	Санал, зөвлөмж	25
5.	Хавсралтууд	26-78

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. Судалгааны үндсэн асуудлууд, судлах хэрэгцээ шаардлага

Төлбөртэй давтлага/дамжаа судалгааг Монгол улсад анх удаа зохион байгуулж байгаа нь дээрх асуудлын цар хүрээг тогтоон энэ асуудлаар Боловсролын яамнаас шийдвэр гаргах хэрэгтэй эсэх, дунд боловсролын чанар үр өгөөж нь төлбөртэй давтлага/дамжаагүйгээр суралцагчдын хэрэгцээг хангаж буй эсэх зэрэг олон асуудалд хариулт өгөх үндэслэлтэй мэдээллийг бий болгоход оршиж байна.

1.2. Судалгааны зорилго, зорилтууд

- Төлбөртэй давтлага/дамжаа бий болсон шалтгаан нөхцлийг судлах
- Төлбөртэй давтлага/дамжааны хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тогтоох
- Төлбөртэй давтлага/дамжааны талаар төрөөс баримтлах бодлого шийдвэр бий болгох хэрэгцээ шаардлагыг судлах
- Төлбөртэй давтлага/дамжааны өнөөгийн байдлыг судалгаанд хамрагдаж буй бусад орнуудтай харьцуулах

1.3. Судалгааны хамрах хүрээг тогтоох түүвэр хийхэд баримталсан арга зүй, өгөгдөл боловсруулалт

Судалгааны түүвэр хийхийн тулд “Төлбөртэй давтлага/дамжаа” судалгаанд оролцож байгаа бусад улсууд түүврээ хэрхэн хийснийг судлан үзлээ.

Монгол улсад дээд боловсрол олгох сургуулиудын тоо хэт олон, олонхи сургуулиуд нь цөөн оюутантай, ихэнх оюутнууд Улаанбаатар хотод суралцдаг зэрэг нь түүврийг бусад улсуудынхтай адилаар хийвэл судалгааны төлөөлөх чадварт нөлөөлөн судалгааны үр дүнг бууруулж болзошгүй байв. Иймд судалгаанд хамрагдах оюутны тоог хэдээр тогтоох тухай нилээд ярилцаж зөвлөлдсөний эцэст 1500 оюутныг хамруулан судалгааг явуулахаар тогтлоо.

Судалгаанд хамрагдвал зохих 1-р дамжааны оюутны нийт тоог 2004-2005 оны хичээлийн жилийн эхний мэдээнд үндэслэн суралцаж буй мэргэжлийн чиглэл, магадлан итгэмжлэгдсэн байдал, эдийн засгийн бүс нутгийн байршлаар гаргах судалгааг хийв. /Хавсралт 1 (Хүснэгт 1, 2)/

Судалгааны түүврийг таван үе шаттайгаар хийв. Үүнд:

Нэгдүгээр үе. Дээрх судалгаагаар төрийн өмчийн магадлан итгэмжлэлд ороогүй сургуулиудын оюутны тоо төдийлөн ихгүй /нийт оюутны 4,6 хувь/ байгаа тул судалгаанд хамруулахгүй байхаар тогтлоо.

Хоёрдугаар үе. Судалгаанд хамрагдах оюутны суралцаж байгаа мэргэжлийн чиглэлийг сонгохдоо хамгийн их эрэлттэй, дунд зэргийн эрэлттэй, эрэлт багатайг нь харгалзан үзлээ.

Манай улсын хувьд бизнес ба удирдлага, хууль эрх зүй, анагаах ухаан, компьютерийн мэргэжлүүд эрэлт ихтэй мэргэжилд, дунд ангийн багш болон инженерийн мэргэжлүүд дунд зэргийн эрэлттэй мэргэжилд, байгалын ухаан, хөдөө аж ахуйн мэргэжлүүд эрэлт багатай мэргэжилд тус тус ордог тул дээрх чиглэлээр суралцагчдаас судалгааг авахаар тогтлоо. Ерөнхий боловсролын сургууль бүр гадаад хэлний хичээлээр англи хэлийг судалж чадахгүй байгаагаас шалтгаалан эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжил болох Англи хэлний орчуулагчийн мэргэжлийг судалгааны сонголтонд оруулаагүй болно.

Гуравдугаар үе. Судалгаанд хамруулахаар сонгосон мэргэжлүүдээр 1-р дамжаанд суралцаж буй оюутны тоог гаргав. /Хавсралт 1 (Хүснэгт 3)/

Судалгаанд хамруулахаар сонгосон мэргэжлээр 1-р дамжаанд суралцаж буй нийт суралцагчдын дотор тухайн мэргэжлээр суралцагчдын эзлэх хувийн жинг харгалзан 1500 оюутнаас судалгаа авсан тохиолдолд эдийн засгийн бүс нутаг бүрээс ямар мэргэжлээр хичнээн оюутныг судалгаанд хамруулахыг тооцож гаргав. /Хавсралт 1 (Хүснэгт 4)/

Дөрөвдүгээр үе. Судалгаанд хамрагдвал зохих оюутны тоог урьдчилан тогтоосны дараа магадлан итгэмжлэгдсэн байдал, суралцаж буй сургуулийн байршлыг харгалзан хуваарилалт хийж үзэхэд нилээд олон сургуульд зочилоход хүрч зардал, цаг хугацаа ихээр шаардагдахаар байв. Иймд эдийн засгийн бүс нутаг, газар зүйн байршлыг харгалзан хөдөө орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа Ховд аймаг дахь МУИС-ын салбар сургууль /Монголын баруун хэсэгт оршдог/, Дорноговь аймаг дахь Анагаах ухааны коллеж /Монголын өмнө хэсэгт оршдог/, Дорнод дахь Багшийн коллеж /Монголын зүүн хэсэгт оршдог/, Дархан хот дахь дээд сургуулиуд /Монголын 2 дахь том хот бөгөөд хойд хэсэгт оршдог/-д зочилж судалгаа авахаар тогтож судалгаанд хамрагдах оюутны тооны хуваарилалтыг хийлээ. /Хавсралт 1 (Хүснэгт 5)/

Тавдугаар үе. Судалгаанд хамруулахаар төлөвлөсөн оюутны тоонд үндэслэн сургууль, мэргэжил бүрээр судалгаа авах оюутны тоог нарийвчлан тогтоож /Хавсралт 2/ судалгаа авах ажлыг эхлүүлэв.

Судалгаа авах ажлыг шуурхай зохион байгуулах зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсролын хэлтсийн дарга Баярт судалгааны ажлын зорилгоо танилцуулж судалгаанд хамрагдах сургуулиудын захирлуудад судалгааны ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх талаар үүрэг даалгавар өгүүллээ.

Судалгааны багийн гишүүд ба Мэдээллийн технологийн үндэсний паркын эрдэм шинжилгээний ажилтнуудад судалгаа авахдаа анхаарах зүйлсийн талаар зөвлөгөө өгч ажиллав. Оюутнуудаас судалгааг авахдаа гүйцэд бөглөсөн эсэхийг богино хугацаанд шалган үзэж бөглөөгүй орхисон асуултуудыг бөглөхийг хүсэж байсан нь судалгааны чанарт сайнаар нөлөөллөө.

Хөдөө орон нутагт байгаа сургуулиудад судалгааны багийн гишүүд өөрсдөө очиж судалгааг авлаа.

Судалгааны өгөгдлийг компьютерт оруулах ажлыг Microsoft Excel хэрэглээний програм ашиглан гүйцэтгэсэн бөгөөд өгөгдлийн алдааг санамсаргүй түүвэр хийх замаар шалган нягталснаас гадна Filter хийх замаар дахин нягтлав.

Өгөгдлийн алдааг нягтлан шалгасны дараа Microsoft Excel хэрэглээний програмаас SPSS програмд өгөгдлийг шилжүүлэн боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

1.4. Судалгааны хязгаарлалт

Судалгааны түүврийг бусад орнуудад хийж гүйцэтгэсэн арга зүйн дагуу явуулсан бөгөөд түүврээ өмнө дурьдсанаар 5 үе шаттайгаар хийсэн нь судалгааны төлөөлөх чадварыг бага зэрэг бууруулсан гэж үзэж байна. Тэгэхдээ судалгааны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд судалгаанд 22 сургуулийг хамруулж, 1476 оюутнаас судалгааг авсан нь Монгол улс дахь төлбөртэй давтлага/дамжааны дүр зургийг нилээд ойролцоогоор харуулахаар болсон гэж үзэж байна.

Судалгааны асуулга хэт ихээс шалтгаалан зарим оюутан “Төлбөртэй давтлага, дамжааны талаарх таны бодол” хэсгийн асуулга бүрийг сайн уншиж ойлголгүйгээр хариулсан байж болзошгүй нь судалгааны үр дүнд муугаар нөлөөлсөн байна. Тухайлбал, “Багш нар төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдсан сурагчдад илүү сайнаар ханддаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 64,4 хувь нь үндсэндээ санал нийлж байна гэж хариулсан боловч “Багш нар төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдсан сурагчдад сайнаар ханддаггүй” гэсэн дээрх бодомжийн эсрэг бодомжтой судалгаанд оролцогчдын 81,7 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл дээрх асуултанд хариулсан сурагчдын 17 орчим хувь нь “ханддаг”, “ханддаггүй” гэдэг үгүүдийн ялгааг төдийлөн анзааралгүй хариултаа сонгосон нь ажиглагдаж байна.

Судалгааны өгөгдлийг оруулж байхад нэг дамжааны үргэлжлэх хугацааг нэг удаа давтлага өгсөн цагаар тооцон бичсэн, төлбөртэй давтлага авахад зарцуулсан зардлын хэмжээг “Би сайн мэдэхгүй байна. Аав, ээж зардлыг төлсөн тул сайн мэднэ” гээд хариулахгүй орхих, ангийнхаа хүүхдүүдийн хэдэн хувь нь ямар хичээлээр давтлага авч байсныг сайн мэдэхгүй байна гэж хариулах, хариулсан ч хичнээн хувь нь болохыг ойролцоогоор хэлэхдээ буруу хэлсэн байж болзошгүй хариултууд олон байсан тул эдгээр үзүүлэлтээр гаргасан тоог болгоомжтой хэрэглэх шаардлагатай гэж үзэж байна.

2.Төлбөрт давтлагын өнөөгийн байдал

2.1. Төлбөрт давтлага/дамжаа бий болсон нөхцөл байдал

Монгол орон ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн 90-ээд оны эхэн үеэс төлбөртэй давтлагын тухай асуудал эцэг, эх, суралцагчид, боловсролын системд ажиллагчдын хүрээнд яригдах болсон юм.

Зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнө буюу 1990-ээд оноос өмнө доор дурьдсан хэд хэдэн шалтгааны улмаас төлбөртэй давтлагын тухай ойлголт бараг байгаагүй гэж хэлэх бүрэн үндэслэлтэй. Үүнд:

- Сургууль, багш нарын зүгээс сургалтын төлөвлөгөөнд төлөвлөсөн зүйлийг сурагчдад эзэмшүүлэх талаар хийж байгаа ажлыг тогтмол шалган гарсан дутагдлыг засахад онцгой анхаарал тавьж байв. Хэрвээ хичээл заадаг сурагчдын сурлага муу байвал тухайн багшийг ажлаас нь халах хүртэл арга хэмжээ авдаг байсан нь багш нарыг хичээлээ сайн заахад нь нөлөөлж байсан
- Багш нар хичээл заадаг сурагчиддаа давтлага зөвлөгөөг үнэ төлбөргүй өгч сурагчдыг сурлагаар хоцрогдохоос урьдчилан сэргийлж байв
- Багшийн цалин хөлс нь тухайн үедээ амьдралаа залгуулахад хүрэлцэхүйц байлаа

90-ээд оны эхэн, дунд үеэд Монгол улсын эдийн засагт хүндрэл бэрхшээл учирч боловсролд зарцуулах төсөвт зардал буурснаас гадна олон зуун багш амьдралаа сайжруулах зорилгоор ажлаасаа гарах явдал түгээмэл болсон нь боловсролын чанарт муугаар нөлөөлөх болов.

Түүнчлэн багш нарын цалин хөлс амьдралаа залгуулахад нь хүрэлцэхгүй болсноос олон арван багш хичээл заадаг сурагчиддаа давтлага зөвлөгөөг төлбөртэй өгөх нь ердийн үзэгдэл болов. Энэ тухай зарим хүмүүс “Төлбөртэй давтлага өгөхийн тулд хичээлээ ор нэрийн төдий заадаг багш ихэссэн” гэж шоглон ярилцах болов.

Боловсролын чанар үр өгөөж буурч байгаа сөрөг үзэгдлийг бага ч гэсэн бууруулах зорилгоор Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас сургууль төгсөх улсын шалгалтыг төвлөрсөн журмаар авах шийдвэрийг гаргасан нь төлбөрт давтлага бий болоход ихээхэн нөлөө үзүүлэв.

90-ээд оны эхэн үеийг хүртэл дунд сургуулийн төгсөлтийн шалгалтыг сургуулиуд өөрсдөө зохион байгуулж ирсэн бөгөөд төрөлх хэл, математик, физик, хими, нийгэм судлал, гадаад хэлний хичээлээр шалгалт өгдөг байв. Гэтэл сургууль төгсөх улсын шалгалтыг төвлөрсөн журмаар авах болсноор дээрх бүх шалгалтуудыг авах цаг хугацааны боломж хомсдон сурагчид төрөлх хэл, математик болон бусад хичээлүүдээс аль нэг хичээлийг нь сонгох журмаар шалгалт өгдөг болов. Энэ байдал нь сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн эсэх талаар манай улсын хувьд одоо болтол судалж амжаагүй байна. Харин дээрх асуудлаар боловсролын салбарт ажиллагчид болон олон нийтийн санаа бодлыг сонсоход хими, физик, гадаад хэлний сургалтын чанар буурахад дээрх шийдвэр ихээхэн үүрэг гүйцэтгэсэн тухай шүүмжлэн ярьж байна.

Төгсөлтийн шалгалтыг төвлөрсөн журмаар авах болсноор төгсөх ангийн сурагчид зөвхөн шалгалт өгөх хичээлдээ голлон анхаарч бусад хичээлийг орхигдуулах болсон тухай багш, олон нийтийн шүүмжлэн хэлэлцдэг болсоор олон жил боллоо.

Ийнхүү төлбөрт давтлага нь боловсролын чанар үр өгөөж буурах, багш нарын цалин хөлс тэдний амьдралд хүрэлцэхгүй болсонтой уялдан гарч ирсэн бөгөөд одоогоор нийгмийн тодорхой хэсэг хүлээн зөвшөөрөх болтлоо өргөжсөн үйл ажиллагаа болов.

Сүүлийн 40 орчим жил их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтыг уралдаант шалгаруулалтын хэлбэрээр авч байгаа бөгөөд 90-ээд оны дунд үеийг хүртэл Боловсролын яам, 90 оны сүүлээс их, дээд сургууль нь уралдаант шалгалтыг зохион байгуулж байна.

Их, дээд сургуульд элсэхийн тулд давтлага авах явдал урьд өмнө нь байсан боловч зах зээлд шилжих шилжилтийн эхэн үеэс төлбөртэй давтлага авах, төлбөртэй дамжаа зохион байгуулах үйл ажиллагаа идэвхижсэн юм. Улмаар их, дээд сургуулиуд өөрсдөө шалгалтыг зохион байгуулах болсноор тухайн сургуулиас зохион байгуулж байгаа дамжаа олширч тухайн сургуулийн багш нараас төлбөртэй давтлага авах нь ихэссэн болно.

Монгол улсын хувьд ерөнхий боловсролын сургууль, төрийн өмчийн их, дээд сургуулиас төлбөртэй дамжааг албан ёсоор зохион байгуулах нь ховор ч төлбөртэй давтлагыг их, дээд сургуулийн багш нар өгөх нь түгээмэл үзэгдэл юм.

Бага, дунд боловсролын тухай Монгол улсын хуулиар ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтыг төлбөртэйгөөр зохион байгуулахыг зөвшөөрсөн бөгөөд үүнээс үүдээд зарим хичээлийг бусад сургуулиас илүү цагаар судалдаг “төлбөртэй дамжаа”-нууд олшров. Үнэндээ гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт гэж нэрлэж байгаа ч гэсэн дээрх сургалтууд нь төлбөртэй дамжааны нэг хэлбэр гэж үзэж байгаатай санал нийлэх хүн цөөнгүй гарна гэж бодож байна.

Төлбөртэй дамжаа, давтлага зохион байгуулна гэсэн зарлал хэвлэл, мэдээллийн хэрэгслээр байнга зарлагдах болов. Эдгээр дамжаа, давтлагыг ихэвчлэн сургууль багш

нарын дутуу заасан болон сурагчдын ойлгоогүй зүйлийг заах, их, дээд сургуулийн уралдаант шалгалтанд бэлтгэхэд туслах зорилгоор зохион байгуулах болов.

Эцэг, эхчүүд хүүхдүүддээ төлбөртэй давтлага өгөх багшийн эрэлд мордож сайн багшаар давтлага өгүүлэхийг зорих боллоо.

Их, дээд сургуулийн багш нар уралдаант шалгалтанд зориулсан ном, сурах бичиг, гарын авлагыг олноор зохиох болсноос гадна төлбөртэй давтлага өгөх нь ихэслээ.

Төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдахгүй бол хүссэн сургуульдаа элсэн орж чадахгүй гэсэн ойлголт түгээмэл болж ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид хэд хэдэн давтлага, дамжаанд суралцах болов.

Төлбөртэй дамжаа, давтлага нь нийгэм хүлээн зөвшөөрөхүйц үйл ажиллагаа болтлоо өргөжсөн боловч энэ талаар Боловсролын яамнаас тусгайлан гаргасан шийдвэр одоогоор байхгүй байна.

2.2. “Төлбөртэй давтлага/дамжаа” судалгааны үр дүн

Төлбөртэй давтлага/дамжаа судалгаанд манай улсын их, дээд сургууль, коллежийн 1-р ангид өдрөөр суралцдаг 1476 оюутан хамрагдсан бөгөөд эдгээрээс 1253 нь нийслэл Улаанбаатарт, 93 нь манай улсын томоохон хот болох Дарханд, 130 нь манай орны баруун, зүүн, өмнө хэсэгт орших Ховд, Дорнод, Дорноговь аймагт тус тус суралцагчид байна. /Хавсралт 3 (Хүснэгт 6)/

БСШУЯ-наас гаргасан мэдээгээр 2003-2004 оны хичээлийн жилд ЕБС-ийн төгсөх ангид суралцагчдын 35,0 хувь нь Улаанбаатарт, 9,3 хувь нь Дархан, Эрдэнэтэд, 55,6 хувь нь бусад аймаг, сумдын сургуульд суралцаж байв.

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 38,1 хувь нь нийслэл Улаанбаатарт, 9,2 хувь нь томоохон хот болох Дархан, Эрдэнэтэд, 36,1 хувь нь бусад аймгийн төвд, 16,6 хувь нь сумын сургууль төгсөгчид байгаа нь судалгааны түүвэр оновчтой болж төлөөлөх чадвар гайгүй болсныг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан нийт оюутны тоог мэргэжлийн чиглэлээр нь гаргахад боловсролын чиглэлээр суралцагчдын эзлэх хувь 16,3 байгаа ба энэ үзүүлэлт бизнес ба удирдлагад 33,9%, хууль эрх зүйд 6,6%, байгалын ухаанд 5,8%, компьютерт 10,0%, инженер техникт 13,3%, хөдөө аж ахуйд 4,1%, анагаах ухаанд 9,9%-тай байна. /Хавсралт 3 (Хүснэгт 7)/

Судалгаанд хамрагдсан оюутны 60,4 хувь нь эрэлт ихтэй мэргэжлээр, 12,7 хувь нь эрэлт багатай мэргэжлээр суралцаж байна. /Хавсралт 3 (Хүснэгт 8)/

Улаанбаатар хотод ЕБС төгсөгчид нь их, дээд сургуулийн эрэлт ихтэй мэргэжлийн ангид голчлон суралцаж байна. Гэтэл хөдөөгийн суманд ЕБС төгссөн хүүхдүүд эрэлт багатай мэргэжлээр л сургуульд элсэн суралцах явдал түгээмэл байдаг байна. Тухайлбал, судалгаагаанд хамрагдсан оюутны 38,1 хувь нь Улаанбаатарт ЕБС төгссөн боловч эрэлт ихтэй мэргэжлээр суралцагчдын 48,9 хувь, эрэлт багатай мэргэжлээр суралцагчдын 18,4 хувийг тус тус Улаанбаатарт ЕБС төгсөгчид эзэлж байна. /Хавсралт 3 (Хүснэгт 9)/

Судалгаанд хамрагдсан оюутны 70,7 хувь нь ядаж төлбөртэй давтлага, дамжааны аль нэгэнд нь хамрагдаж байсан ба энэ үзүүлэлт Улаанбаатарт 73,3%, Дарханд 64,2%, Эрдэнэтэд 65,2%, бусад аймгийн төвд 75,0%, хөдөөгийн суманд 59%-тай байна. /Хавсралт 3 (Хүснэгт 10)/

Судалгаанд хамрагдсан оюутны 40,3 хувь нь төлбөртэй давтлага, дамжаанд хоёуланд нь хамрагдаж байсан ба энэ үзүүлэлт Улаанбаатарт 45,5%, Дарханд 29,9%, Эрдэнэтэд 36,2%, бусад аймгийн төвд 43,0%, хөдөөгийн суманд 26,6%-тай байна. /Хавсралт 3 (Хүснэгт 11)/

Төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдалгүйгээр дунд сургуульд эзэмшсэн мэдлэг чадвараа ашиглан дунд сургууль төгсөх шалгалтаа амжилттай өгч чадах байсан уу? гэсэн асуултанд хариулсан оюутны 55,5 хувь нь боломжтой байсан, 23,9 хувь нь боломжтой байсан байх, 6,2 хувь нь хэлж мэдэхгүй байна, 12,1 хувь нь боломжгүй байсан байх, 2,3 хувь нь огт боломжгүй байсан гэж хариулсан байна. /Хавсралт 3 (Хүснэгт 12)/

Төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдалгүйгээр дунд сургуульд эзэмшсэн мэдлэг чадвараа ашиглан их, дээд сургуульд элсэх шалгалтаа амжилттай өгч чадах байсан уу? гэсэн асуултанд хариулсан оюутны 31,2 хувь нь боломжтой байсан, 23,7 хувь нь боломжтой байсан байх, 12,3 хувь нь хэлж мэдэхгүй байна, 23,7 хувь нь боломжгүй байсан байх, 9,1 хувь нь огт боломжгүй байсан гэж хариулсан байна. /Хавсралт 3 (Хүснэгт 13)/

Эндээс харахад ЕБС-д эзэмшүүлсэн мэдлэг чадвар нь олонхи сурагчид дунд сургуулиа төгсөхөд хангалттай байдаг боловч их, дээд сургуульд элсэхэд нь бүрэн хангалттай байж чаддаггүй байна.

2.2.1. “Төлбөртэй давтлага” судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан нийт оюутны 33,1 хувь буюу 489 оюутан төлбөртэй давтлаганд хамрагдаж байгаагүй гэж хариулсан байна. Эдгээр оюутны төлбөртэй давтлагад хамрагдаж байгаагүй шалтгааныг тодруулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Ямар нэгэн төлбөртэй давтлагагүйгээр би шалгалтуудаа амжилттай өгч чадна гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 17,5 хувь
- Төлбөртэй давтлага авах нь миний хувьд хэт их үнэтэй байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 9,6 хувь
- Төлбөртэй сайн давтлагын талаарх мэдээлэл надад байгаагүй. Мэдээлэл байсан бол би төлбөртэй давтлага авах байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 3,7 хувь
- Найз нөхөд маань үнэ төлбөргүйгээр надад тусалж байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 6,8 хувь
- Давтлага авах гэсэн боловч нэгэнтээ оройтсон байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 2,8 хувь
- Өөр бусад шалтгаантай гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 4,5 хувь нь тус тус хариулсан байна.

Дээрхээс дүгнэн үзэхэд ЕБС төгсөгчдийн 29,8 хувь нь л төлбөртэй давтлагад хамрагдах хүсэлгүй байсан байна. Өөрөөр хэлбэл 10 сурагч тутмын 7 нь төлбөртэй давтлаганд хамрагдах хүсэлтэй байжээ.

Судалгаанд оролцогчдын 495 /33,5 хувь/ нь төлбөртэй давтлага авч байгаагүй, 575 /39,0 хувь/ нь 1 хичээлээр, 336 /22,8 хувь/ нь 2 хичээлээр, 70 /4,7 хувь/ нь 3 ба түүнээс дээш хичээлээр төлбөртэй давтлага авч байсан байна.

Төлбөртэй давтлага авах нь миний хувьд их үнэтэй байсан гэж хариулсан суралцагчдын амжиргааны түвшинг судлан үзэхэд эдгээр суралцагчдын 61,3 хувь нь амжиргааны түвшин дунд зэрэг, 33,1 хувь нь амжиргааны түвшин муу, 2,1 хувь нь амжиргааны түвшин маш муу өрхийн хүүхдүүд байна. /Хавсралт 3 (Хүснэгт 14)/

Судалгаанд хамрагдсан 3 оюутан тутмын 2 нь, бизнес ба удирдлага, анагаах ухааны чиглэлээр суралцагчдын 72,6-73,0 хувь нь тус тус төлбөртэй давтлага авч байсан байна./Хавсралт 4 (Хүснэгт 15)/

Ерөнхий боловсролын сургууль төгсөх жилээ суралцагчдын хэдэн хувь нь төлбөртэй давтлага авч байсныг төгссөн газраар нь судлан үзэхэд Улаанбаатарт төгсөгчдийн 67,0 хувь, Дарханд төгсөгчдийн 59,3 хувь, Эрдэнэтэд төгсөгчдийн 62,3 хувь, бусад аймгийн төвд төгсөгчдийн 72,0 хувь, хөдөөгийн сумын сургууль төгсөгчдийн 56,6 хувь нь тус тус төлбөртэй давтлага авч байжээ. Эндээс үзэхэд төлбөртэй давтлагыг аймгийн төвд сургууль төгсөгчид бусад газарт төгсөгчдөөс илүүтэй авдаг байна. /Хавсралт 4 (Хүснэгт 16)/

Эцэг эхийн боловсролын түвшин өндөрсөх тутам хүүхдээ төлбөртэй давтлагад хамруулахыг дэмждэг байна. Тухайлбал, бакалавр ба түүнээс дээш боловсролтой эцэг, эхийн 70,5-70,7 хувь нь хүүхэддээ төлбөртэй давтлага авч байсан байна. Гэтэл дээрх үзүүлэлт бүрэн дунд боловсролтой эцэг, эхийн хувьд 62,7-65,0 хувьтай байна. /Хавсралт 4 (Хүснэгт 17, 18)/

Эцэг эхийн ажил эрхлэлт, албан тушаал хүүхдээ төлбөртэй давтлагад хамруулахад ихээхэн нөлөөтэй байна. Тухайлбал, дээд түвшний удирдах ажилтан, бие даан ажиллаж буй мэргэжилтэн, компанын эзэн хамтран эзэмшигч ажилтай хүмүүсийн 77,8-83,0 хувь нь хүүхэддээ төлбөртэй давтлага авч байсан байна. Гэтэл дээрх үзүүлэлт мэргэжилтэй ажилчин, малчин, ажилгүй хүмүүсийн хувьд 43,7-59,4 хувьтай байна. /Хавсралт 5 (Хүснэгт 19, 20)/

Судалгаанд оролцогчдын 1,4 хувь нь амжиргааны түвшингээ маш сайн, 13,3 хувь сайн, 68,4 хувь нь дунд зэрэг, 15,8 хувь нь муу, 1,2 хувь нь маш муу гэж тус тус үнэлсэн бөгөөд амжиргааны түвшин сайтай өрхөөс суралцагчдын 75,9 хувь, амьжиргааны түвшин муутай өрхийн 58,0 хувь нь тус тус төлбөртэй давтлага авч байжээ. Өөрөөр хэлбэл амжиргааны төвшин төлбөртэй давтлага авахад зохих хэмжээгээр нөлөөлдөг байна. /Хавсралт 6 (Хүснэгт 21)/

Судалгаанд оролцогчдын 54,2 хувь нь Математикаар, 12,7 хувь нь Химизэр, 12,0 хувь нь төрөлх хэлний, 9,8 хувь нь нийгмийн ухааны, 4,7 хувь нь гадаад хэлний, 3,4 хувь нь физикийн хичээлээр тус тус төлбөртэй давтлага авч байсан байна. /Хавсралт 6 (Хүснэгт 22)/

Суралцагчдын 43,0 хувь нь зөвхөн шалгалтандаа сайн бэлтгэх, 29,1 хувь нь өмнө үзсэн хичээл, сэдвүүдийг системтэйгээр ойлгох, сэргээн санах, 19,5 хувь нь дунд сургуульд заагдсан хичээлүүдийг илүү сайн ойлгох зорилгоор тус тус төлбөртэй давтлага авч байсан байна. Тухайлбал, математикийн хичээлийн хувьд шалгалтандаа бэлтгэхийн тулд 434 сурагч буюу судалгаанд оролцогчдын 29,4 хувь нь төлбөртэй давтлага авч байсан байна. /Хавсралт 6 (Хүснэгт 23, 24)/

Хамгийн их цагаар төлбөртэй давтлага авч байсан хичээлүүдийн хувьд төлбөртэй давтлагыг хэнээс авдаг байсан тухай судлан үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн 40,6 хувь нь дээд сургуулийн багшаас, Дархан, Эрдэнэт болон бусад аймаг, сумын сургууль төгсөгчдийн 42,1-61,3 хувь нь тухайн хичээлийг заадаг багшаасаа тус тус төлбөртэй давтлага авдаг байсан байна. /Хавсралт 7 (Хүснэгт 25)/
- Математикийн хичээлээр төлбөртэй давтлага авч байсан Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн 40,8 хувь нь дээд сургуулийн багшаас, Дархан, Эрдэнэт болон бусад аймаг, сумын сургууль төгсөгчдийн 40,0-

60,2 хувь нь тухайн хичээлийг заадаг багшаасаа тус тус давтлага авдаг байсан байна. /Хавсралт 7 (Хүснэгт 26)/

- Төрөлх хэлний хичээлээр хамгийн олон цагийн төлбөртэй давтлага авч байсан гэж хариулсан суралцагч нь судалгаанд оролцогчдын 3,3 хувь болж байна. Өөрөөр хэлбэл энэ хичээлээр бараг төлбөртэй давтлага авдаггүй байна. Энэ хичээлийн төлбөртэй давтлагыг ихэвчлэн ЕБС-ийн багшаасаа авдаг байна. /Хавсралт 7 (Хүснэгт 27)/
- Химийн хичээлээр төлбөртэй давтлага авч байсан Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн 38,6 хувь нь дээд сургуулийн багшаас, Дархан, Эрдэнэт болон бусад аймаг, сумын сургууль төгсөгчдийн 40,0-100,0 хувь нь тухайн хичээлийг заадаг багшаасаа тус тус давтлага авдаг байсан байна. /Хавсралт 7 (Хүснэгт 28)/

Судалгааны дүнгээс харахад Улаанбаатар хотын хувьд Математик, Химийн хичээл заадаг их, дээд сургуулийн багш нар голдуу төлбөртэй давтлагыг өгдөг байна.

Төлбөртэй давтлагын 13,9 хувь нь ганцаарчилсан хэлбэрээр, 17,2 хувь нь 2-3 сурагчтай, 15,4 хувь нь 4-5 сурагчтай, 53,5 хувь нь 5-аас дээш сурагчтай тус тус хамтатган зохион байгуулагдаж байсан байна. Эрдэнэт хотод төлбөртэй давтлагыг ихэвчлэн 2-3 сурагчтай хамтатган зохион байгуулдаг бол бусад газарт 5-аас дээш сурагчтайгаар хичээллэдэг байна. /Хавсралт 7 (Хүснэгт 29)/

Төрөлх хэлний хичээлийн төлбөртэй давтлагын 8,2 хувь нь ганцаарчилсан хэлбэрээр, 16,3 хувь нь 2-3 сурагчтай, 10,2 хувь нь 4-5 сурагчтай, 65,3 хувь нь 5-аас дээш сурагчтай тус тус хамтатган зохион байгуулагдаж байсан бол дээрх үзүүлэлт математикийн хичээлээр харгалзан 14,6%, 16,2%, 14,6%, 54,7% байна. /Хавсралт 7 (Хүснэгт 30)/

Төлбөртэй давтлагад хамрагдсан хугацааг судлахад энэ асуултанд хариулсан 958 оюутны 15,4 хувь нь хичээлийн жилийн туршид тогтмол, 8,1 хувь нь хичээлийн жилийн туршид хааяа нэг, 32,3 хувь нь сүүлийн хагас жил/улиралд хааяа нэг, 44,2 хувь нь сүүлийн хагас жил/улиралд тогтмол хамрагдсан гэжээ. /Хавсралт 7 (Хүснэгт 31)/

7 хоногт хэдэн цагаар төлбөртэй давтлагад хамрагдаж байсныг судлахад энэ асуултанд хариулсан 965 оюутны 3,0 хувь нь 1 цагаар, 20,0 хувь нь 2 цагаар, 35,8 хувь нь 3-4 цагаар, 41,2 хувь нь 4-өөс дээш цагаар давтлага авч байсан гэжээ. /Хавсралт 7 (Хүснэгт 32)/

Төлбөртэй давтлага авах болсон шалтгаан ба төлбөртэй давтлагын үр дүнгийн талаарх оюутны бодлыг судлахад энэ асуултанд хариулсан 973 оюутны 4,1 хувьд нь ердөө тус болоогүй, 67,5 хувьд нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн, 20,5 хувьд нь маш их нөлөөлсөн, 7,9 хувь нь хэлж мэдэхгүй байна гэжээ. Өөрөөр хэлбэл төлбөртэй давтлагад хамрагдсан оюутны 88,0 хувь нь давтлагыг үр дүнтэй болсон гэж үнэлжээ. /Хавсралт 8 (Хүснэгт 33)/

Төлбөртэй давтлага нь бусдын жишгийг дагаж хамрагдсан хүүхдүүдэд 70,7 хувиар нөлөөлсөн бол эцэг эхийн санаачлагаар хамрагдсан хүүхдүүдэд 85,3 хувиар, зөвхөн шалгалтандаа сайн бэлтгэх зорилгоор хамрагдсан хүүхдүүдэд 88,8 хувиар тус тус сайнаар нөлөөлсөн байна. /Хавсралт 8 (Хүснэгт 34)/

Төрөлх хэлээр төлбөртэй давтлага авсан хүүхдийн 87,7 хувь, гадаад хэлээр 88,2 хувь, Математикаар 87,7 хувь, Нийгмийн ухаанаар 95,0 хувь, Химээр 89,1 хувь нь давтлагын үр дүнг сайн болсон гэж хариулсан байна. /Хавсралт 8 (Хүснэгт 35)/

Төлбөртэй давтлага нь 2003 оноос өмнө ЕБС төгсөгчдийн 85,7 хувьд, 2003 онд төгсөгчдийн 90,6 хувьд, 2004 онд төгсөгчдийн 87,7 хувьд тус тус сайнаар нөлөөлсөн байна. /Хавсралт 8 (Хүснэгт 36)/

Төлбөртэй давтлага нь маш сайн амжиргаатай өрхөд амьдардаг хүүхдийн 93,4 хувьд, сайн амжиргаатай өрхөд амьдардаг хүүхдийн 88,2 хувьд, дунд зэрэг амжиргаатай өрхөд амьдардаг хүүхдийн 90,2 хувьд, муу амжиргаатай өрхөд амьдардаг хүүхдийн 76,7 хувьд, маш муу амжиргаатай өрхөд амьдардаг хүүхдийн 75,0 хувьд тус тус сайнаар нөлөөлсөн байна. /Хавсралт 8 (Хүснэгт 37)/

Төлбөртэй давтлагыг хичээлийн жилийн турш юмуу сүүлийн улиралд тогтмол авах, 7 хоногт олон цагаар авах, цөөн хүүхэдтэйгээр зохион байгуулах нь илүү үр дүнтэй нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. /Хавсралт 8 (Хүснэгт 38, 39, 40)/

Хамгийн олон цагаар төлбөртэй давтлага авсан хичээлдээ хичнээн төгрөгийн төлбөр төлсөн бэ? гэсэн асуултанд хариулсан хариултаас харахад хамгийн бага нь 1000 төгрөг, хамгийн их нь 1,0 сая төгрөг, дунджаар 59,4 мянган төгрөг зарцуулсан байна.

Төлбөртэй давтлагыг гол нь их, дээд сургуулийн уралдаант шалгалтанд бэлтгэх зорилгоор авдаг болох нь эрэлт ихтэй мэргэжлээр суралцагчид дунджаар 65,7 мянган төгрөг зарцуулснаас харагдаж байна. /Хавсралт 9 (Хүснэгт 41)/

Улаанбаатарт байрладаг их, дээд сургуульд элсэгчид төлбөртэй давтлага авахад дунджаар 62,8 мянган төгрөг зарцуулсан нь Дархан, бусад аймагт байрладаг сургуульд элсэгчдийн зарцуулснаас харгалзан 26,8 болон 18,3 мянган төгрөгөөр тус тус илүү байна. /Хавсралт 9 (Хүснэгт 42)/

Төрийн өмчийн их, дээд сургуульд элсэгчид төлбөртэй давтлага авахад дунджаар 63,2 мянган төгрөг зарцуулсан нь төрийн бус өмчийн их, дээд сургуульд элсэгчдийн зарцуулснаас 12,6 мянган төгрөгөөр илүү байна. /Хавсралт 9 (Хүснэгт 43)/

Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд элсэгчид төлбөртэй давтлага авахад дунджаар 61,9 мянган төгрөг зарцуулсан бол магадлан итгэмжлэгдээгүй сургуульд элсэгчид 43,0 мянган төгрөг зарцуулсан байна. /Хавсралт 9 (Хүснэгт 44)/

Судалгаагаар эцэг, эх нь хоёулаа бакалавр болон түүнээс дээш боловсролтой бол хүүхдээ төлбөртэй давтлага авахад нь 75,8 мянган төгрөг зарцуулдаг байхад аль нэг нь бакалавр болон түүнээс дээш боловсролтой бол 70,0 мянган төгрөг зарцуулдаг байна. Түүнчлэн боловсролгүй болон бага боловсролтой эцэг, эхчүүд төлбөртэй давтлагад 21,6-25,6 мянган төгрөг зарцуулдаг байна. /Хавсралт 9 (Хүснэгт 45, 46)/

Нэг хичээлийн төлбөртэй давтлагын дундаж төлбөрийг хот, хөдөөгөөр нь гаргахад Улаанбаатарт 73,4 мянга, Дарханд 41,5 мянга, Эрдэнэтэд 53,1 мянга, бусад аймгийн төвд 54,3 мянга, сумдад 43,1 мянган төгрөг байна. Гадаад хэлний хичээлээр давтлага өгч байгаа багшид өгч байгаа дундаж төлбөр 106,2 мянган төгрөг байгаа бөгөөд дээрх үзүүлэлт математик, химийн хичээлийн хувьд 62,2 мянган төгрөг байна. /Хавсралт 9 (Хүснэгт 47)/

Бизнес удирдлагын чиглэлээр суралцагчид дунд сургууль төгсөх жилээ төлбөртэй давтлага авахад нь 72,3 мянган төгрөг зарцуулсан бол хөдөө аж ахуйн чиглэлээр суралцагчид 35,0 мянган төгрөг зарцуулжээ. Төлбөртэй давтлагад зарцуулдаг мөнгөний хэмжээ хот, хөдөөгийн хувьд ихээхэн ялгаатай байна. Тухайлбал бизнес удирдлагын чиглэлээр Улаанбаатараас суралцагчид давтлага авахад 88,0 мянган төгрөг зарцуулсан бол дээрх чиглэлээр суралцагчид сумын сургуулиас элссэн хүүхдүүд 39,2 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. /Хавсралт 9 (Хүснэгт 48)/

Их, дээд сургуульд элссэний дараа сургалтын төлбөрийг хэн хариуцах нь төлбөртэй давтлага авахаар зарцуулж буй мөнгөний хэмжээнд нэг их нөлөөлдөггүй байна. Тухайлбал төрийн албан хаагчдын хүүхдүүд өөрөө зардлаа хариуцаж буй хүүхдүүдтэй ойролцоо хэмжээний мөнгийг давтлага авахдаа зарцуулсан байна. /Хавсралт 9 (Хүснэгт 49)/

Харин сургалтын төлбөрөө өөрөө төлөхээр төлөвлөж байсан хүүхдүүд төрөөр даалгахаар төлөвлөж байсан хүүхдүүдээс илүү их мөнгийг давтлага авахад зарцуулсан байна. /Хавсралт 9 (Хүснэгт 50, 51)/

2.2.2. “Төлбөртэй дамжаа” судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан 1473 оюутан төлбөртэй дамжаанд хамрагдаж байсан эсэх талаарх асуултанд хариулсан бөгөөд эдгээрийн 44,5 хувь нь буюу 656 оюутан төлбөртэй дамжаанд хамрагдаж байсан байна.

Төлбөртэй дамжаанд хамрагдаж байгаагүй гэж хариулсан 817 оюутны шалтгааныг тодруулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Ямар нэгэн төлбөртэй дамжаагүйгээр би шалгалтуудаа амжилттай өгч чадна гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 18,8 хувь
- Төлбөртэй дамжаанд суух нь миний хувьд хэт их үнэтэй байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 12,9 хувь
- Төлбөртэй сайн дамжааны талаарх мэдээлэл надад байгаагүй. Мэдээлэл байсан бол би төлбөртэй дамжаанд хамрагдах байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 5,1 хувь
- Би төлбөртэй давтлага авч байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 14,0 хувь
- Найз нөхөд маань үнэ төлбөргүйгээр надад тусалж байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 9,8 хувь
- Дамжаанд хамрагдах гэсэн боловч нэгэнтээ оройтсон байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 3,5 хувь
- Өөр бусад шалтгаантай гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 4,0 хувь нь тус тус хариулсан байна.

Дээрхээс дүгнэн үзэхэд ЕБС төгсөгчдийн 42,6 хувь нь л төлбөртэй дамжаанд хамрагдах хүсэлгүй байсан бөгөөд үүний 14,0 хувь нь төлбөртэй давтлага авч байсан тул давхардуулах хүсэлгүй байснаас болжээ. Өөрөөр хэлбэл 10 сурагч тутмын 6 нь төлбөртэй дамжаанд хамрагдах хүсэлтэй байсан байна.

Төлбөртэй дамжаанд явах нь миний хувьд их үнэтэй байсан гэж хариулсан суралцагчдын амжиргааны түвшинг судлан үзэхэд эдгээр суралцагчдын 60,0 хувь нь амжиргааны түвшин дунд зэрэг, 35,3 хувь нь амжиргааны түвшин муу, 2,6 хувь нь амжиргааны түвшин маш муу өрхийн хүүхдүүд байна. /Хавсралт 9 (Хүснэгт 52)/

Судалгаанд хамрагдсан суралцагчдын 47,0 хувь нь Ерөнхий боловсролын сургуулийн зохион байгуулсан төлбөртэй дамжаанд хамрагдсан бол их, дээд сургуулиас зохион байгуулсан дамжаанд 29,9 хувь нь хамрагдсан байна. Улаанбаатарт зохион байгуулсан төлбөртэй дамжааны 58,5 хувийг их, дээд сургуулиас зохион байгуулсан бол аймаг, сумдад төлбөртэй дамжааг ихэвчлэн ЕБС-иудаас зохион байгуулж байна. Хавсралт 10 (Хүснэгт 53)/

Судалгаанд хамрагдсан суралцагчдын 16,9 хувь нь Бизнес ба удирдлагын чиглэлээр суралцахаар төлбөртэй дамжаанд хамрагдсан бол анагаах ухаан, боловсрол, инженер техникийн чиглэлээр дээрх үзүүлэлт харгалзан 5,1%, 5,3%, 5,5% байна. Хавсралт 10 (Хүснэгт 54)/

Улаанбаатарт төгсөгчдийн 51,2 хувь, Дарханд төгсөгчдийн 32,8 хувь, Эрдэнэтэд төгсөгчдийн 37,7 хувь, бусад аймгийн төвд төгсөгчдийн 45,7 хувь, хөдөөгийн сумын сургууль төгсөгчдийн 28,7 хувь нь тус тус төлбөртэй дамжаанд хамрагдсан байна. /Хавсралт 10 (Хүснэгт 55)/

Төлбөртэй дамжаанд хэн заадаг байсныг судлан үзэхэд Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн 59,4 хувь нь дээд сургуулийн багшаар, Дархан, Эрдэнэт болон бусад аймаг, сумын сургууль төгсөгчдийн 65,2-81,5 хувь нь ЕБС-ийн багшаар тус тус хичээлээ заалгаж байжээ. /Хавсралт 13 (Хүснэгт 56)/

Бакалавр ба түүнээс дээш боловсролтой эцгийн 61,6%, эхийн 61,29 нь хүүхдээ төлбөртэй дамжаанд хамруулж байсан ба энэ үзүүлэлт суурь боловсролтой эцэг, эхийн хувьд харгалзан 37,0%, 45,2% байна. /Хавсралт 10 (Хүснэгт 57, 58)/

Эцэг эхийн ажил эрхлэлт, албан тушаал хүүхдээ төлбөртэй давтлагад хамруулахад нэг их нөлөөгүй нь судалгаагаар харагдлаа. Тухайлбал, дээд түвшний удирдах ажилтай эцгийн 58,3%, эхийн 64,7% нь хүүхдээ төлбөртэй дамжаанд хамруулж байсан бол энэ үзүүлэлт энгийн ажилчин эцэг, эхийн хувьд харгалзан 57,9%, 70,8% байна. /Хавсралт 11 (Хүснэгт 59, 60)/

Амжиргааны түвшин сайтай өрхөөс суралцагчдын 55,0 хувь нь төлбөртэй дамжаанд хамрагдсан бол энэ үзүүлэлт амжиргааны түвшин сайн өрхөд 53,1%, амжиргааны түвшин дунд зэрэг өрхөд 43,9%, амжиргааны түвшин муу өрхөд 34,9%, амжиргааны түвшин маш муу өрхөд 44,4% байна. /Хавсралт 12 (Хүснэгт 61)/

Суралцагчдын 22,6 хувь нь өмнө үзсэн хичээл, сэдвүүдийг системтэйгээр ойлгох, сэргээн санах, 19,6 хувь нь хичээлээр заагдсан зарим сэдэвт хичээлүүдийг илүү сайн ойлгох, 11,6 хувь нь ЕБС-ийн олгож буй мэдлэг/чадвар нь хангалттай биш байснаас, 11,4 хувь нь хичээлийн хоцрогдлоо арилгах зорилгоор тус тус төлбөртэй давтлага авч байсан байна. /Хавсралт 12 (Хүснэгт 62)/

Төлбөртэй дамжааны 15,7 хувь нь 1-5 сурагчтай, 30,7 хувь нь 6-15 сурагчтай, 31,6 хувь нь 16-30 сурагчтай, 21,9 хувь нь 30-аас дээш сурагчтай тус тус хичээллэж байсан байна. /Хавсралт 13 (Хүснэгт 63)/

Төлбөртэй дамжаанд хамрагдсан хугацааг судлахад энэ асуултанд хариулсан 651 оюутны 17,4 хувь нь шалгалт эхлэхээс 1 жилийн өмнөөс, 39,9 хувь нь шалгалт эхлэхээс 3-6 сарын өмнөөс, 28,9 хувь нь шалгалт эхлэхээс 2 сарын өмнөөс, 13,8 хувь нь шалгалт эхлэхээс 1 сарын өмнөөс дамжаанд хамрагдсан гэжээ. /Хавсралт 13 (Хүснэгт 64)/

Нэг төлбөртэй дамжааны үргэлжлэх дундаж хугацаа нь 78 цаг байгаа бөгөөд байршлаар нь гаргахад Улаанбаатарт 80 цаг, Дарханд 45 цаг, Эрдэнэтэд 92 цаг, бусад аймгийн төвд 83 цаг, хөдөөгийн суманд 55 цаг байна. 2004 онд ерөнхий боловсролын дунд сургууль төгсөгчдийн хамрагдсан дамжааны хичээллэсэн дундаж хугацаа 81 цаг байгаа бол энэ үзүүлэлт 2003 онд төгсөгчдийн хувьд 60 цаг, 2003 оноос өмнө төгсөгчдийн хувьд 57 цаг байна. /Хавсралт 13 (Хүснэгт 65, 66)/

Төлбөртэй дамжааны үр дүнгийн талаарх оюутны бодлыг судлахад энэ асуултанд хариулсан 650 оюутны 4,8 хувьд нь ердөө тус болоогүй, 72,2 хувьд нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн, 16,2 хувьд нь маш их нөлөөлсөн, 6,9 хувь нь хэлж мэдэхгүй байна гэжээ. Өөрөөр хэлбэл төлбөртэй давтлагад хамрагдсан оюутны 88,4 хувь нь давтлагыг үр дүнтэй болсон гэж үнэлжээ. /Хавсралт 14 (Хүснэгт 67)/

Төлбөртэй дамжаа нь бусдын жишгийг дагаж хамрагдсан хүүхдүүдэд 63,1 хувиар нөлөөлсөн бол эцэг эхийн санаачлагаар хамрагдсан хүүхдүүдэд 83,8 хувиар, ЕБС-ийн олгож буй мэдлэг/чадвар нь хангалттай биш байснаас болж хамрагдсан хүүхдүүдэд 85,9 хувиар, өмнө үзсэн хичээл, сэдвүүдийг системтэйгээр ойлгох, сэргээн санах

зорилгоор хамрагдсан хүүхдүүдэд 90,3 хувиар тус тус сайнаар нөлөөлсөн байна. /Хавсралт 15 (Хүснэгт 68)/

Төлбөртэй дамжаа нь 2004 оноос өмнө ЕБС төгсөгчдийн 86,5 хувьд, 2004 онд төгсөгчдийн 88,6 хувьд тус тус сайнаар нөлөөлсөн байна. /Хавсралт 15 (Хүснэгт 69)/

Төлбөртэй дамжаа нь маш сайн амжиргаатай өрхөд амьдардаг хүүхдийн 63,7 хувьд, сайн амжиргаатай өрхөд амьдардаг хүүхдийн 89,6 хувьд, дунд зэрэг амжиргаатай өрхөд амьдардаг хүүхдийн 89,8 хувьд, муу амжиргаатай өрхөд амьдардаг хүүхдийн 84,0 хувьд, маш муу амжиргаатай өрхөд амьдардаг хүүхдийн 87,5 хувьд тус тус сайнаар нөлөөлсөн байна. /Хавсралт 15 (Хүснэгт 70)/

Төлбөртэй дамжаанд шалгалт эхлэхээс 1 жилийн өмнөөс хамрагдсан хүүхдийн 93,8 хувьд, шалгалт эхлэхээс 3-6 сарын өмнөөс хамрагдсан хүүхдийн 91,5 хувьд, шалгалт эхлэхээс 2 сарын өмнөөс хамрагдсан хүүхдийн 83,9 хувьд, шалгалт эхлэхээс 1 сарын өмнөөс дамжаанд хамрагдсан хүүхдийн 82,2 хувьд тус тус төлбөртэй дамжаа үр дүнгээ өгсөн байна. /Хавсралт 15 (Хүснэгт 71)/

5 хүртэл хүүхэдтэй хичээллэж байсан төлбөртэй дамжаанд хамрагдсан хүүхдийн 95,0 хувьд, 6-15 хүүхэдтэй дамжаанд хамрагдсан хүүхдийн 91,0 хувьд, 16-30 хүүхэдтэй дамжаанд хамрагдсан хүүхдийн 85,9 хувьд, 30-аас дээш хүүхэдтэй дамжаанд хамрагдсан хүүхдийн 83,8 хувьд тус тус төлбөртэй дамжаа үр дүнгээ өгсөн байна. /Хавсралт 15 (Хүснэгт 72)/

Төлбөртэй дамжаанд хамрагдсан 621 суралцагч дамжаанд хамрагдахдаа төлсөн төлбөрийнхөө талаарх мэдээллийг өгсөн бөгөөд хамгийн бага нь 500 төгрөг, хамгийн их нь 400,0 мянган төгрөг, дунджаар 33,0 мянган төгрөг зарцуулсан байна.

Төлбөртэй дамжааг гол нь их, дээд сургуулийн уралдаант шалгалтанд бэлтгэх зорилгоор авдаг болох нь эрэлт ихтэй мэргэжлээр суралцагчид дунджаар 35,1 мянган төгрөг зарцуулснаас харагдаж байна. /Хавсралт 16 (Хүснэгт 73)/

Улаанбаатарт байрладаг их, дээд сургуульд элсэгчид төлбөртэй дамжаанд хамрагдахад дунджаар 34,9 мянган төгрөг зарцуулсан нь Дархан, бусад аймагт байрладаг сургуульд элсэгчдийн зарцуулснаас харгалзан 14,7 болон 14,5 мянган төгрөгөөр тус тус илүү байна. /Хавсралт 16 (Хүснэгт 74)/

Төрийн өмчийн их, дээд сургуульд элсэгчид төлбөртэй дамжаанд хамрагдахад дунджаар 32,0 мянган төгрөг зарцуулсан нь төрийн бус өмчийн их, дээд сургуульд элсэгчдийн зарцуулснаас 5,5 мянган төгрөгөөр бага байна. /Хавсралт 16 (Хүснэгт 75)/

Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд элсэгчид төлбөртэй дамжаанд хамрагдахад дунджаар 33,4 мянган төгрөг зарцуулсан бол магадлан итгэмжлэгдээгүй сургуульд элсэгчид 29,6 мянган төгрөг зарцуулсан байна. /Хавсралт 16 (Хүснэгт 76)/

Судалгаагаар эцэг, эх нь хоёулаа бакалавр болон түүнээс дээш боловсролтой бол хүүхдээ төлбөртэй давтлага авахад нь 36,0 мянган төгрөг зарцуулдаг байхад аль нэг нь бакалавр болон түүнээс дээш боловсролтой бол 34,9 мянган төгрөг зарцуулдаг байна. Түүнчлэн боловсролгүй болон бага боловсролтой эцэг, эхчүүд төлбөртэй дамжаанд 3,0-10,6 мянган төгрөг зарцуулдаг байна. /Хавсралт 16 (Хүснэгт 77, 78)/

Төлбөртэй дамжааны дундаж төлбөрийг хот, хөдөөгөөр нь гаргахад Улаанбаатарт 38,9 мянга, Дарханд 30,3 мянга, Эрдэнэтэд 22,6 мянга, бусад аймгийн төвд 27,1 мянга, сумдад 34,3 мянган төгрөг байна. /Хавсралт 16 (Хүснэгт 79)/

Бизнес удирдлагын чиглэлээр суралцагчид дунд сургууль төгсөх жилээ төлбөртэй дамжаанд хамрагдахад 37,1 мянган төгрөг зарцуулсан бол хөдөө аж ахуйн чиглэлээр

суралцагчид 26,6 мянган төгрөг, боловсролын чиглэлээр суралцагчид 22,3 мянган төгрөг зарцуулжээ. /Хавсралт 16 (Хүснэгт 80)/

2.2.3. “Танай ангийнхан” судалгааны үр дүн

Ангийн чинь хүүхдүүдээс хэдэн хувь нь дунд сургууль төгсөх жилээ төлбөрт давтлага авсан бэ? гэсэн асуултанд хариулт өгсөн хүмүүсийн хариултын дундажыг гаргахад ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн 67,1 хувь нь төлбөртэй давтлага, дамжаанд хамрагдсан байна. Дээрх үзүүлэлт Улаанбаатарт 66,8%, Дарханд 62,1%, Эрдэнэтэд 66,0%, бусад аймгийн төвд 71,7%, хөдөөгийн суманд 58,9% байна. /Хавсралт 17 (Хүснэгт 82)/

Танай ангийнхны хэдэн хувь нь дараах хичээлээр төлбөртэй давтлага авсан бэ? гэсэн асуултанд хариулт өгсөн хүмүүсийн хариултын дундажыг гаргахад ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн 39,7 хувь нь төрөлх хэлний хичээлээр, 20,6 хувь нь гадаад хэлний хичээлээр, 54,0 хувь нь математикийн хичээлээр, 24,7 хувь нь нийгмийн ухааны хичээлээр, 16,1 хувь нь түүхийн хичээлээр, 14,4 хувь нь биологийн хичээлээр, 22,0 хувь нь химийн хичээлээр, 21,1 хувь нь физикийн хичээлээр тус тус төлбөртэй давтлага, дамжаанд хамрагдсан байна. /Хавсралт 17 (Хүснэгт 82)/

2.2.4. Төлбөртэй давтлага, дамжааны талаарх таны бодол судалгааны үр дүн

“Зөвхөн чинээлэг айлын хүүхдүүд төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдах боломжтой” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 23,7 хувь нь санал огт нийлэхгүй, 47,1 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 25,4 хувь нь санал нийлж байгаа, 3,9 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 18 (Хүснэгт 83)/

“Их, дээд сургуулийн багш нарын төлбөртэй давтлага нь ЕБС-ийн багш нарынхаас илүү” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 7,1 хувь нь санал огт нийлэхгүй, 26,6 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 50,4 хувь нь санал нийлж байгаа, 15,7 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 18 (Хүснэгт 84)/

“Ангидаа хичээл заадаг багшаасаа төлбөрт давтлага өгнө үү гэж хүсэх нь түгээмэл байдаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 5,8 хувь нь санал огт нийлэхгүй, 18,0 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 59,1 хувь нь санал нийлж байгаа, 17,1 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 19 (Хүснэгт 85)/

“Тухайн хичээлийг ойлгоогүй хүүхдэд хандан төлбөрт давтлага өгье гэж хичээл заадаг багш нар санал болгодог” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 14,8 хувь нь санал огт нийлэхгүй, 27,1 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 49,4 хувь нь санал нийлж байгаа, 8,7 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 19 (Хүснэгт 86)/

“Төлбөртэй давтлага/дамжаа зохион байгуулах нэг гол зорилго нь багш нарыг нэмэлт орлоготой болгоход оршдог” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 9,9 хувь нь санал огт нийлэхгүй, 25,6 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 50,9 хувь нь санал нийлж байгаа, 13,6 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 20 (Хүснэгт 87)/

“Багш нар төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдсан сурагчдад илүү сайнаар ханддаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 9,3 хувь нь санал огт нийлэхгүй, 26,3 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 49,2 хувь нь санал нийлж байгаа, 15,2 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 20 (Хүснэгт 88)/

“Багш нар төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдсан сурагчдад сайнаар ханддаггүй” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 27,7 хувь нь санал огт нийлэхгүй, 54,0 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 15,8 хувь нь санал нийлж байгаа, 2,5 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 21 (Хүснэгт 89)/

“Багш нар өөрийн сурагчдадаа төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдахыг санал болгох ёсгүй” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 13,7 хувь нь санал огт нийлэхгүй, 40,8 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 34,0 хувь нь санал нийлж байгаа, 11,6 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 21 (Хүснэгт 90)/

“Төлбөртэй давтлага/дамжаа нь чанартай боловсрол эзэмших ганц арга зам” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 20,8 хувь нь санал огт нийлэхгүй, 50,6 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 23,4 хувь нь санал нийлж байгаа, 5,3 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 22 (Хүснэгт 91)/

“Төлбөртэй давтлага/дамжаа нь төгсөлтийн болон элсэлтийн шалгалтыг амжилттай өгөх ганц арга зам” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 13,6 хувь нь санал огт нийлэхгүй, 51,4 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 29,0 хувь нь санал нийлж байгаа, 6,0 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 22 (Хүснэгт 92)/

“Ерөнхийдөө төлбөрт давтлага/дамжаанууд нь өндөр үнэтэй” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 3,0 хувь нь санал огт нийлэхгүй, 17,0 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 62,1 хувь нь санал нийлж байгаа, 17,8 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 23 (Хүснэгт 93)/

“Сургалтын хөтөлбөрт хэт их зүйлийг оруулснаас шалтгаалан сурагчид төлбөртэй давтлага/дамжаанд хамрагддаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 12,0 хувь нь санал огт нийлэхгүй, 44,2 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 35,0 хувь нь санал нийлж байгаа, 8,8 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 23 (Хүснэгт 94)/

“Сургалтын хөтөлбөр нь төгсөлтийн болон элсэлтийн шалгалтын сэдвүүдийг бүрэн хамарч чадаагүй учраас сурагчид төлбөрт давтлага/дамжаанд хамрагддаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 8,6 хувь нь санал огт нийлэхгүй, 40,8 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 40,6 хувь нь санал нийлж байгаа, 10,1 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 24 (Хүснэгт 95)/

“Сурагчид илүү ихийг мэдэхийн тулд төлбөрт давтлага/дамжаанд хамрагддаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 2,3 хувь нь санал огт нийлэхгүй, 11,4 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 62,6 хувь нь санал нийлж байгаа, 23,7 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 24 (Хүснэгт 96)/

“Боловсролын систем нь хэн нэгэн сурагч төлбөртэй давтлага/дамжаанд суухгүйгээр мэдлэг чадвартай болох нөхцлийг бүрдүүлэх ёстой” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 3,1 хувь нь санал огт нийлэхгүй, 10,8 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 38,7 хувь нь санал нийлж байгаа, 47,4 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 25 (Хүснэгт 97)/

“Багш нар хичээлээ бүрэн ойлгуулж чадаагүйгээс сурагчид төлбөрт давтлага авч байна” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 5,8 хувь нь санал огт нийлэхгүй, 30,5 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 50,5 хувь нь санал нийлж байгаа, 13,1 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 25 (Хүснэгт 98)/

“Дунд сургуулийн сургалтын чанар хангалтгүй байгаагаас сурагчид төлбөрт давтлага/дамжаанд хамрагдахад хүрдэг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 3,8 хувь нь санал огт нийлэхгүй, 27,5 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 53,8 хувь нь санал нийлж байгаа, 15,0 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 26 (Хүснэгт 99)/

“Зөвхөн сурлага муутай сурагчид төлбөртэй давтлага/дамжааг сонирхдог” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 27,7 хувь нь санал огт нийлэхгүй, 56,4 хувь нь

санал нийлэхгүй байгаа бол 12,9 хувь нь санал нийлж байгаа, 3,0 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 26 (Хүснэгт 100)/

“Төлбөртэй давтлага/дамжаанд суухгүйгээр амжилттай суралцах боломжгүй” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 28,5 хувь нь санал огт нийлэхгүй, 56,0 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 12,2 хувь нь санал нийлж байгаа, 3,3 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 27 (Хүснэгт 101)/

“Голдуу дүнгээ ахиулах зорилгоор сурагчид төлбөрт давтлага/дамжаанд хамрагддаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 12,2 хувь нь санал огт нийлэхгүй, 45,1 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 38,1 хувь нь санал нийлж байгаа, 4,6 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 27 (Хүснэгт 102)/

“Сурагчид их, дээд сургуульд орох боломжоо нэмэгдүүлэх зорилгоор төлбөрт давтлага/дамжаанд хамрагддаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 1,6 хувь нь санал огт нийлэхгүй, 6,3 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 65,3 хувь нь санал нийлж байгаа, 26,7 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 28 (Хүснэгт 103)/

“Төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдсан сурагчид бусад сурагчдаа бодвол их, дээд сургуульд орох нь их байдаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 3,6 хувь нь санал огт нийлэхгүй, 29,4 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 54,6 хувь нь санал нийлж байгаа, 12,3 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 28 (Хүснэгт 104)/

“Эцэг эхийн санаачлагаар л сурагчид төлбөртэй давтлагад суудаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 11,2 хувь нь санал огт нийлэхгүй, 53,2 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 32,1 хувь нь санал нийлж байгаа, 3,5 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 29 (Хүснэгт 105)/

“Чинээлэг айлын хүүхдүүд илүү сайн багш хөлсөлж чаддаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 5,7 хувь нь санал огт нийлэхгүй, 16,7 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 51,1 хувь нь санал нийлж байгаа, 26,4 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 29 (Хүснэгт 106)/

“Төлбөртэй дамжаа нь төлбөрт давтлагаас илүү үр дүнтэй” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 6,8 хувь нь санал огт нийлэхгүй, 46,6 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 39,4 хувь нь санал нийлж байгаа, 7,1 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 30 (Хүснэгт 107)/

“Шалгалтад сайн бэлтгэхийн тулд төлбөртэй дамжаанд сууснаас төлбөрт давтлага авах нь илүү чухал” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 5,1 хувь нь санал огт нийлэхгүй, 37,2 хувь нь санал нийлэхгүй байгаа бол 46,9 хувь нь санал нийлж байгаа, 10,9 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна. /Хавсралт 30 (Хүснэгт 108)/

2.2.5. Төлбөртэй давтлага, төлбөртэй дамжааны талаарх судалгаанд оролцогчдын санал бодолд хийсэн харьцуулалт

Судалгаанд хамрагдсан нийт оюутны 66,9 хувь төлбөртэй давтлаганд, 44,5 хувь нь төлбөртэй дамжаанд тус тус хамрагдсан байна. ЕБС төгсөгчдийн 40,3 хувь нь төлбөртэй давтлага, дамжаанд хоёуланд нь хамрагдаж байсан тухай өмнө өгүүлсэн. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 26,6 хувь нь зөвхөн төлбөртэй давтлагад, 4,2 хувь нь зөвхөн төлбөртэй дамжаанд хамрагдсан байна. Эндээс харахад суралцагчдын хувьд төлбөртэй давтлагад илүүтэй хамрагдахыг хичээдэг байна.

Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн олонхи нь дээд сургуулийн багшаас төлбөртэй давтлага авах, дээд сургуулиас зохион байгуулж байгаа төлбөртэй дамжаанд хамрагдахыг хичээдэг байна. Харин аймаг, сумдад их, дээд сургууль төдийлөн байдаггүй нь ерөнхий боловсролын сургуулийн багшаасаа давтлага авахад хүргэдэг байна. Энэ нь “Их, дээд сургуулийн багш нарын төлбөртэй давтлага нь ЕБС-ийн багш нарынхаас илүү” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 66,1 хувь нь санал нийлж байгаагаар давхар нотлогдож байна.

Төлбөртэй давтлага нь уг давтлагад хамрагдсан суралцагчдынхаа 88,0 хувьд, төлбөртэй дамжаа нь хамрагдсан суралцагчдынхаа 88,4 хувьд нь үр дүнгээ өгснөөс үзэхэд хоёулаа үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

Төлбөртэй давтлага авахад хамгийн бага нь 1000 төгрөг, хамгийн их нь 1,0 сая төгрөг, дунджаар 59,4 мянган төгрөг зарцуулсан бол төлбөртэй дамжаанд хамгийн бага нь 500 төгрөг, хамгийн их нь 400,0 мянган төгрөг, дунджаар 33,0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэг хичээлийн төлбөртэй давтлагын дундаж төлбөр Улаанбаатарт 73,4 мянга, Дарханд 41,5 мянга, Эрдэнэтэд 53,1 мянга, бусад аймгийн төвд 54,3 мянга, сумдад 43,1 мянган төгрөг байгаа бол төлбөртэй дамжааны дундаж төлбөр Улаанбаатарт 38,9 мянга, Дарханд 30,3 мянга, Эрдэнэтэд 22,6 мянга, бусад аймгийн төвд 27,1 мянга, сумдад 34,3 мянган төгрөг байна. Эндээс харахад төлбөртэй давтлагын үнэ хөлс дамжааныхаас 1,5-2 дахин их байна.

Төлбөртэй давтлага нь төлбөрт дамжаанаас илүү үр дүнтэй гэж судалгаанд оролцогчдын 53,5 хувь нь үзэж байгаа бол шалгалтад сайн бэлтгэхийн тулд төлбөртэй дамжаанд сууснаас төлбөрт давтлага авах нь илүү чухал гэж судалгаанд оролцогчдын 57,8 хувь нь үзсэн байна.

Судалгааны үр дүнгээр төлбөртэй давтлага авах нь төлбөртэй дамжаанд хамрагдахаас илүү ашигтай гэсэн бодол санал суралцагчдын дунд байдаг нь харагдаж байна.

2.2.6. Төлбөртэй давтлага, төлбөртэй дамжаа ба боловсрол дахь сүүдрийн эдийн засаг

БСШУЯ-ны “Боловсролын салбарын удирдлага, санхүүжилт, төсөвт зардлын гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ (Судалгааны тайлан) 2000 – 2004 он” судалгаагаар ерөнхий боловсролын сургуулийн багшийн сарын үндсэн цалингийн дундаж 59,4 мянган төгрөг байна.

Төлбөртэй давтлага судалгаанаас нэг удаагийн төлбөртэй давтлагад дунджаар хэдэн хүүхэд суралцаж байсан, дунджаар хэдэн цагаар хичээллэдэг байсан гэсэн үзүүлэлтийг гаргах бололцоогүй байлаа. Иймд төлбөртэй давтлагын 1 цагийн дундаж хөлсийг ойролцоогоор тооцоолж чадаагүй болно.

Төлбөртэй давтлагад хамрагдсан сурагч дунджаар 59411 төгрөг төлсөн нь ерөнхий боловсролын сургуулийн багшийн сарын үндсэн цалингийн дундажтай тэнцүү байна. Өөрөөр хэлбэл 12 сурагчид төлбөртэй давтлага өгөхөд л ЕБС-ийн багш жилийнхээ үндсэн цалинтай тэнцэхүйц орлого олохоор байна.

Нэг удаагийн төлбөртэй дамжаа нь дунджаар 78 цаг хичээллэж байсан ба нэг дамжаанд дунджаар 18-19 хүүхэд хамрагдаж, хүүхэд бүрээс дунджаар 33,0 мянган төгрөгийн төлбөр авч байсан байна. Өөрөөр хэлбэл нэг дамжаа хичээллүүлэхэд ойролцоогоор 594,0-627,0 мянган төгрөг олж байсан гэсэн тооцоо гарч байна. Дамжаанд заадаг багш олсон мөнгөнийхөө 40 хувийг нь байр түрээслэх болон 10

хувийг нь татварт өгсөн гэж үзэхэд л 1 цаг хичээл заасны хөлс ойролцоогоор 3800-4000 төгрөг болж байна.

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн татварын байцаагчдаас багш нар төлбөртэй сургалт явуулсныхаа татварыг тушаадаг эсэхийг асуухад бараг тушаадаггүй гэж хариулсан юм.

ЕБС-ийн багшийн 1 цаг хичээл заасны дундаж хөлс 782 төгрөг байгаа бол 1 цагийн төлбөртэй давтлага өгсний хөлс дээр дурьдсанчлан 3800-4000 төг байна. Эндээс харахад ЕБС-ийн багш нарын төлбөртэй дамжаа хичээллүүлэн олсон хөдөлмөрийн хөлсний дундаж үнэлгээ хичээл зааж олсон хөлснөөс 5 дахин илүү байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд төлбөртэй давтлага авахад хамгийн багадаа 54,5 сая төгрөг зарцуулсан байна. Өөрөөр хэлбэл 2004-2005 оны хичээлийн жилд их, дээд сургуулийн 1-р дамжаанд суралцаж байгаа 34,2 мянган сурагчид төлбөртэй давтлагад хамгийн багадаа 1262,5 сая төгрөг зарцуулсан гэж үзэж болохоор байна. Харин 2004-2005 оны хичээлийн жилд их, дээд сургуулийн 1-р дамжаанд суралцаж байгаа суралцагчдын төлбөртэй давтлага авахад зарцуулсан байж болох хөрөнгийн дээд хязгаарыг ойролцоогоор тогтооход 2006,3 сая төгрөг болж байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд төлбөртэй дамжаанд хамрагдахын тулд 33,3 сая төгрөг зарцуулсан байна. Өөрөөр хэлбэл 2004-2005 оны хичээлийн жилд их, дээд сургуулийн 1-р дамжаанд суралцаж байгаа 34,2 мянган сурагчид төлбөртэй дамжаанд ойролцоогоор хамрагдахад хамгийн багадаа 771,7 сая төгрөг зарцуулсан гэж үзэж болохоор байна.

Дээр дурьдсанчлан зөвхөн ерөнхий боловсролын сургууль төгсөн их, дээд сургуульд элсэгчдэд төлбөртэй давтлага, дамжаа өгснөөс математик, гадаад хэл, хими, биологи, физик, төрөлх хэлний хичээл заадаг багш, мэргэжилтнүүд 2003-2004 оны хичээлийн жилд хамгийн багадаа 2 тэрбум төгрөг олсон байна.

Ерөнхий боловсролд зарцуулсан улсын төсвийн урсгал зарлага 2003 онд 54,3 тэрбум төгрөг, 2004 онд 65,1 тэрбум төгрөг байсан бөгөөд ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн төлбөртэй давтлага, дамжаанд зарцуулсан байж болох хөрөнгийн дүн хамгийн багадаа төсөвт зардлын 3,1-3,7 хувьтай тэнцүү байна.

3. ДҮГНЭЛТ

Дүгнэлт 1. Монгол улсад төлбөртэй давтлага, дамжаанд хамрагдан мэдлэг, чадвараа дээшлүүлэх асуудал нь ЕБС-д суралцагчдын олонхийг хамарсан үзэгдэл болсон байна. Төлбөртэй давтлага, дамжааг зөвхөн Улаанбаатар болон томоохон хотуудад л байдаг зүйл гэж олон хүмүүс үздэг ч судалгаанаас хөдөөд ч дээрх үйл ажиллагаа ихээхэн өргөжсөн нь харагдав.

Нотолгоо.

- ⇒ Судалгаанд хамрагдсан оюутны 70,7 хувь нь ерөнхий боловсролын сургууль төгсөх жилээ төлбөртэй давтлага, дамжааны аль нэгэнд нь хамрагдаж байсан ба энэ үзүүлэлт Улаанбаатарт 73,3%, Дарханд 64,2%, Эрдэнэтэд 65,2%, бусад аймгийн төвд 75,0%, хөдөөгийн суманд 59%-тай байна.
- ⇒ Судалгаанд хамрагдсан оюутны 40,3 хувь нь төлбөртэй давтлага, дамжаанд хоёуланд нь хамрагдаж байсан ба энэ үзүүлэлт Улаанбаатарт 45,5%, Дарханд 29,9%, Эрдэнэтэд 36,2%, бусад аймгийн төвд 43,0%, хөдөөгийн суманд 26,6%-тай байна.

Дүгнэлт 2. Төлбөртэй давтлага, дамжаа нь боловсрол дахь тэгш биш байдлыг улам гүнзгийрүүлж, суралцагчдын мэдлэг, чадвар эцэг, эхийнх нь амьдралын боломжоос шалтгаалах нөхцлийг бий болгох сөрөг талтай нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Нотолгоо.

- ⇒ Төлбөртэй давтлага авах нь миний хувьд хэт их үнэтэй байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 9,6 хувь хариулсан бөгөөд эдгээр суралцагчдын 61,3 хувь нь амжиргааны түвшин дунд зэрэг, 33,1 хувь нь амжиргааны түвшин муу, 2,1 хувь нь амжиргааны түвшин маш муу өрхийн хүүхдүүд байна.
- ⇒ Дээд түвшний удирдах ажилтан, бие даан ажиллаж буй мэргэжилтэн, компанийн эзэн хамтран эзэмшигч ажилтай хүмүүсийн 77,8-83,0 хувь нь хүүхэддээ төлбөртэй давтлага авч байсан бол мэргэжилтэй ажилчин, малчин, ажилгүй хүмүүсийн 43,7-59,4 хувь нь хүүхэддээ төлбөртэй давтлага авч байсан байна.
- ⇒ Эцэг, эх нь хоёулаа бакалавр болон түүнээс дээш боловсролтой бол хүүхдээ төлбөртэй давтлага авахад нь 75,8 мянган төгрөг зарцуулдаг байхад боловсролгүй болон бага боловсролтой эцэг, эхчүүд төлбөртэй давтлагад 21,6-25,6 мянган төгрөг зарцуулдаг байна.
- ⇒ Нэг хичээлийн төлбөртэй давтлагын дундаж төлбөрийг хот, хөдөөгөөр нь гаргахад Улаанбаатарт 73,4 мянга, Дарханд 41,5 мянга, Эрдэнэтэд 53,1 мянга, бусад аймгийн төвд 54,3 мянга, сумдад 43,1 мянган төгрөг байна.
- ⇒ Төлбөртэй дамжаанд суух нь миний хувьд хэт их үнэтэй байсан гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 12,9 хувь хариулсан бөгөөд эдгээр суралцагчдын 60,0 хувь нь амжиргааны түвшин дунд зэрэг, 35,3 хувь нь амжиргааны түвшин муу, 2,6 хувь нь амжиргааны түвшин маш муу өрхийн хүүхдүүд байна.
- ⇒ Эцэг, эх нь хоёулаа бакалавр болон түүнээс дээш боловсролтой бол хүүхдээ төлбөртэй давтлага авахад нь 36,0 мянган төгрөг зарцуулдаг байхад боловсролгүй болон бага боловсролтой эцэг, эхчүүд төлбөртэй дамжаанд 3,0-10,6 мянган төгрөг зарцуулдаг байна.

Дүгнэлт 3. Багшийн ёс зүй алдагдсан нь төлбөртэй давтлага, дамжааны хүрээ өргөжихэд нөлөөлж байна. Түүнчлэн хичээл заадаг багш болон суралцах гэж байгаа их, дээд сургуулийнхаа багшаас авч буй төлбөртэй давтлага, дамжаа нь боловсролын салбарт авилгал бий болох нэг нөхцөл болж болзошгүй байна.

Нотолгоо.

- ⇒ “Багш нар хичээлээ бүрэн ойлгуулж чадаагүйгээс сурагчид төлбөрт давтлага авч байна” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 50,5 хувь нь санал нийлж байгаа, 13,1 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.
- ⇒ “Багш нар өөрийн сурагчдадаа төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдахыг санал болгох ёсгүй” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 34,0 хувь нь санал нийлж байгаа, 11,6 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.
- ⇒ “Тухайн хичээлийг ойлгоогүй хүүхдэд хандан төлбөрт давтлага өгье гэж хичээл заадаг багш нар санал болгодог” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 49,4 хувь нь санал нийлж байгаа, 8,7 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.
- ⇒ “Багш нар төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдсан сурагчдад илүү сайнаар ханддаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 49,2 хувь нь санал нийлж байгаа, 15,2 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.
- ⇒ “Төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдсан сурагчид бусад сурагчдаа бодвол их, дээд сургуульд орох нь их байдаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 54,6 хувь нь санал нийлж байгаа, 12,3 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.

Дүгнэлт 4. Төлбөртэй давтлага, дамжаа нь хэдийгээр сурагч, эцэг, эхчүүд хүлээн зөвшөөрөхүйц үзэгдэл болсон хэдий ч суралцагчид төлбөртэй сургалтанд хамрагдахгүйгээр чанартай боловсролыг эзэмших боломжоор ерөнхий боловсролын сургууль, багш нар хангах ёстой гэж үзсээр байгаа нь харагдав.

Нотолгоо.

- ⇒ “Боловсролын систем нь хэн нэгэн сурагч төлбөртэй давтлага/дамжаанд суухгүйгээр мэдлэг чадвартай болох нөхцлийг бүрдүүлэх ёстой” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 38,7 хувь нь санал нийлж байгаа, 47,4 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.
- ⇒ “Төлбөртэй давтлага/дамжаанд суухгүйгээр амжилттай суралцах боломжгүй” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 28,5 хувь нь санал огт нийлэхгүй, 56,0 хувь нь санал нийлэхгүй байна.
- ⇒ “Дунд сургуулийн сургалтын чанар хангалтгүй байгаагаас сурагчид төлбөрт давтлага/дамжаанд хамрагдахад хүрдэг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 53,8 хувь нь санал нийлж байгаа, 15,0 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.
- ⇒ “Төлбөртэй давтлага/дамжаа зохион байгуулах нэг гол зорилго нь багш нарыг нэмэлт орлоготой болгоход оршдог” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 50,9 хувь нь санал нийлж байгаа, 13,6 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.

Дүгнэлт 5. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн төлбөртэй давтлага, дамжаанд хамрагдах үндсэн шалтгаан нь их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтыг амжилттай өгөхөд оршдог байна.

Нотолгоо.

- ⇒ “Сурагчид их, дээд сургуульд орох боломжоо нэмэгдүүлэх зорилгоор төлбөрт давтлага/дамжаанд хамрагддаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 65,3 хувь нь санал нийлж байгаа, 26,7 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.

- ⇒ “Төлбөртэй давтлага/дамжаанд хамрагдсан сурагчид бусад сурагчдаа бодвол их, дээд сургуульд орох нь их байдаг” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 54,6 хувь нь санал нийлж байгаа, 12,3 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.
- ⇒ “Сургалтын хөтөлбөр нь төгсөлтийн болон элсэлтийн шалгалтын сэдвүүдийг бүрэн хамарч чадаагүй учраас сурагчид төлбөрт давтлага/дамжаанд хамрагддаг” гэсэн бодомжтой 40,6 хувь нь санал нийлж байгаа, 10,1 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.

Дүгнэлт 6. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчид их, дээд сургуульд элсэх хангалттай мэдлэг чадварыг эзэмшиж чадахгүй байгаа нь төлбөртэй давтлага, дамжаанд хамрагдах гол шалтгаан болж байна.

Нотолгоо.

- ⇒ Ямар нэгэн төлбөртэй давтлагагүйгээр би шалгалтуудаа амжилттай өгч чадна гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 17,5 хувь нь л хариулсан байна.
- ⇒ Ямар нэгэн төлбөртэй дамжаагүйгээр би шалгалтуудаа амжилттай өгч чадна гэж судалгаанд хамрагдсан нийт оюутны 18,8 хувь нь л хариулсан байна.
- ⇒ Судалгаанд хамрагдсан суралцагчдын 11,5 хувь нь ЕБС-ийн олгож буй мэдлэг/чадвар нь хангалттай биш байснаас төлбөртэй дамжаанд хамрагдсан байна.
- ⇒ “Төлбөртэй давтлага/дамжаа нь төгсөлтийн болон элсэлтийн шалгалтыг амжилттай өгөх ганц арга зам” гэсэн бодомжтой судалгаанд оролцогчдын 29,0 хувь нь санал нийлж байгаа, 6.0 хувь нь бүрэн дэмжиж байна гэж хариулсан байна.

Дүгнэлт 7. Ерөнхий боловсролын сургууль дахь төлбөртэй давтлага, дамжаа нь боловсролын салбарт сүүдрийн эдийн засаг бий болсныг харуулж байна.

Нотолгоо.

- ⇒ Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн төлбөртэй давтлага, дамжаанд зарцуулсан байж болох хөрөнгийн дүн хамгийн багадаа ерөнхий боловсролын төсөвт зардлын 3,1-3,7 хувьтай тэнцүү байна.

4. САНАЛ, ЗӨВЛӨМЖ.

- ⇒ Төлбөртэй давтлага, дамжаа нь боловсролын чанарыг сайжруулахад зохих нөлөөтэй боловч ядуу өрхийн болон хөдөөгийн сумдын хүүхдүүд хамрагдах боломж муутай байгаа нь судалгаанаас харагдаж байна. Иймд хүүхэд бүрт тэгш боломж олгох зорилгоор үндэсний хэмжээнд гарч буй телевизээр сургууль төгсөх болон их, дээд сургууль, коллежид элсэгчдэд зориулсан сургалтын нэвтрүүлгүүдийг хийх шаардлагатай байна. Энэ сургалтын нэвтрүүлэгт мэдлэг, чадвар, заах арга сайтай багш нараар хичээл заалгах хэрэгтэй гэж үзэж байна.
- ⇒ Төлбөртэй давтлага, дамжааны эерэг, сөрөг талыг нарийвчлан судлах ажлыг БСШУЯ, боловсролын судалгаа хариуцсан байгууллагууд хийх шаардлагатай байна.
- ⇒ Эцэг, эх, суралцагчдын хүсэлтээр мэргэжлийн хүмүүс төлбөртэй давтлага өгөх болон хувийн хэвшлийн байгууллагаас зохион байгуулж байгаа төлбөртэй дамжаа хичээллүүлэх асуудал нь тухайн суралцагчийн хэрэгцээг хангаж байгаа бол БСШУЯ-наас дээрх асуудлуудыг хориглох нь утга учиргүй зүйл тул энэ талаар ямар нэг шийдвэр гаргах хэрэггүй гэж үзэж байна.
- ⇒ Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг сайжруулах замаар төлбөртэй давтлага, дамжаанд хамрагдагчдын хувь хэмжээг бууруулах шаардлагатай байна. Хэдийгээр төлбөртэй давтлага, дамжаа нь суралцагчдын эрэлт хэрэгцээг хангаж байгаа боловч “Багш нар хичээлээ бүрэн ойлгуулж чадаагүйгээс сурагчид төлбөрт давтлага авч байна”, “Төлбөртэй давтлага/дамжаа зохион байгуулах нэг гол зорилго нь багш нарыг нэмэлт орлоготой болгоход оршдог” гэж судалгаанд оролцогчдын олонхи үзсэнийг харгалзан үзэж БСШУЯ, аймаг, нийслэлийн боловсролын газар, сургууль, багш нар сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулах тодорхой ажлыг зохион байгуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл төлбөртэй давтлага, дамжааг БСШУЯ-наас албан ёсоор зөвшөөрвөл боловсролын байгууллага, багш нарын нэр хүнд, ёс зүйд сөргөөр нөлөөлөх аюултайг анхааралдаа авах шаардлагатай байна.
- ⇒ ЕБС-иуд сургуулийнхаа сурагчдад зориулан төлбөртэй дамжаа хичээллүүлэх, хичээл заадаг багш сурагчиддаа төлбөртэй давтлага өгөхийг тус тус хориглосон шийдвэрийг БСШУЯ-наас гарган мөрдүүлэх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл ЕБС болон хичээл заадаг багш сурагчдынхаа мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж буй давтлага, дамжааг үнэ төлбөргүйгээр зохион байгуулах ёстой гэсэн шаардлагыг мөрдөн ажиллах хэрэгтэй гэсэн саналтай байна.
- ⇒ Бусад орнуудын их, дээд сургуулийн элсэлтийн журмыг нарийвчлан судалж, Монголын их, дээд сургуулиудын элсэлтийн шалгалтын журмыг боловсронгуй болгох арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- ⇒ Юуны өмнө их, дээд сургуулиудын элсэлтийн шалгалтын одоогийн журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах жижиг өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай юм. Үүнд:
 - Их, дээд сургуулиудын элсэлтийн шалгалтыг салбар сургуулиуд болон факультетаас тус тусдаа зохион байгуулахгүйгээр нэгдсэн журмаар зохион байгуулж оноо өндөртэй шалгуулагч нь суралцах хуваариа эхлэн сонгодог байх (Жишээлбэл Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн элсэлтийн шалгалтын журмын заалтыг анхаарах гэх мэт)
 - Зөвхөн эцэг, эх, ерөнхий боловсролын сургуулиудын суралцагчдын хүсэлтээр л их, дээд сургуулиуд элсэлтийн уралдаант шалгалтанд зориулсан дамжааг хичээллүүлдэг болох
 - Их, дээд сургуулиудаас эрхлэн зохион байгуулсан элсэлтийн уралдаант шалгалтанд зориулсан дамжаанд хичээл заасан багшийг тухайн жилийн

элсэлтийн комисст аль болохоор ажиллуулахгүй байх чиглэлийг баримтлах

Хавсралт 1

Хүснэгт 1. 2004-2005 оны хичээлийн жилд бакалаврын боловсрол олгох өдрийн 1-р ангиудад суралцагчдын тоо

Мэргэжлийн чиглэл		Нийт оюутны тоо						
		Баруун бүс /Хо, Бө, Ув, За, Го/	Хангайн бүс /Ор, Хе, Бу, Ар, Өв, Бх/	Төвийн бүс /Сэ, Да, Тө, Ду, До, Гс, Өм/	Зүүн бүс /Дд, Хэ, Сү/	Улаанбаатар	Бүгд	Бүгдэд эзлэх хувь
14	Боловсрол	533	465	121	148	2376	3643	10.7%
21	Урлаг	0	0	0	0	962	962	2.8%
22	Хүмүүнлэгийн ухаан	79	106	44	45	3782	4056	11.9%
31	Нийгмийн болон зан үйлийн ухаан	96	161	15	0	3293	3565	10.4%
32	Сэтгүүл зүй ба мэдээлэл	0	0	0	0	561	561	1.6%
34	Бизнес ба удирдлага	230	531	463	75	6614	7913	23.1%
38	Хууль эрх зүй	49	0	0	0	1742	1791	5.2%
42	Амьдралын тухай ухаан	0	0	0	0	260	260	0.8%
44	Физикийн шинжлэх ухаан	0	0	71	0	628	699	2.0%
46	Математик ба статистик	0	0	0	0	508	508	1.5%
48	Компьютер	19	22	0	16	1027	1084	3.2%
52	Инженер техник	0	127	134	0	2096	2357	6.9%
54	Үйлдвэрлэл	11	163	88	0	1308	1570	4.6%
58	Барилга архитектур	0	0	6	0	761	767	2.2%
62	Хөдөө аж ахуй, ой болон загасны аж ахуй	0	0	99	0	678	777	2.3%
64	Мал эмнэлэг	0	0	0	0	165	165	0.5%
72	Анагаах ухаан	103	0	205	0	1479	1787	5.2%
76	Нийгмийн хамгаалал	0	0	0	32	219	251	0.7%
81	Үйлчилгээ	0	0	0	0	580	580	1.7%
84	Тээвэр	0	0	0	0	24	24	0.1%
85	Хүрээлэн буй орчин	18	32	27	0	538	615	1.8%
86	Аюулгүй байдал	0	0	0	0	252	252	0.7%
	Бүгд	1138	1607	1273	316	29853	34187	100%

Хавсралт 1 /үргэлжлэл/

Хүснэгт 2. Их, дээд сургууль, коллежийн 1-р дамжааны оюутны тоо

Мэргэжлийн чиглэл	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	Бүгд	Бүгдэд эзлэх хувь
1-р дамжааны оюутны нийт тоо	1138	1607	1273	316	29853	34187	100.0
- Магадлан итгэмжлэгдсэн төрийн өмчийн сургуульд сурдаг оюутан	986	947	830	225	15297	18285	53.5
- Магадлан итгэмжлэгдсэн төрийн бус өмчийн сургуульд сурдаг оюутан		35			7182	7217	21.1
- Магадлан итгэмжлэгдээгүй төрийн өмчийн сургуульд сурдаг оюутан	68	294		91	1111	1564	4.6
- Магадлан итгэмжлэгдээгүй төрийн бус өмчийн сургуульд сурдаг оюутан	84	331	443		6263	7121	20.8

Хүснэгт 3. Судалгааны хамрах хүрээ

	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	Бүгд
34 Бизнес ба удирдлага	218	306	463	0	6601	7588
38 Хууль эрх зүй	49	0	0	0	1501	1550
72 Анагаах ухаан	103	0	205	0	1479	1787
48 Компьютер	0	0	0	0	999	999
14 Боловсрол	507	465	121	148	2376	3617
52 Инженер техник	0	113	134	0	2041	2288
42 Амьдралын тухай ухаан	0	0	0	0	260	260
44 Физикийн шинжлэх ухаан	0	0	71	0	628	699
62 Хөдөө аж ахуй	0	0	99	0	678	777
Бүгд	877	884	1093	148	16563	19565

Хавсралт 1 /үргэлжлэл/

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдвал зохих нийт оюутны тоо /Урьдчилан тооцооноор/

		Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	Бүгд
34	Бизнес ба удирдлага	17	24	35		507	583
38	Хууль эрх зүй	4				115	119
72	Анагаах ухаан	8		16		113	137
48	Компьютер					77	77
14	Боловсрол	39	35	9	11	182	276
52	Инженер техник		9	10		157	176
42	Амьдралын тухай ухаан			0		20	20
44	Физикийн шинжлэх ухаан			5		48	53
62	Хөдөө аж ахуй			8		52	60
	Бүгд	68	68	83	11	1271	1501

Хүснэгт 5. Судалгаанд хамруулахаар төлөвлөсөн оюутны тоо

		Баруун бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	Бүгд
34	Бизнес ба удирдлага	10	40		500	550
38	Хууль эрх зүй	10			90	100
72	Анагаах ухаан		30		120	150
48	Компьютер				100	100
14	Боловсрол	40	10	40	160	250
52	Инженер техник		30		170	200
42	Амьдралын тухай ухаан				40	40
44	Физикийн шинжлэх ухаан				50	50
62	Хөдөө аж ахуй		10		50	60
	Бүгд	60	120	40	1280	1500

Хавсралт 2
Судалгаанд хамруулахаар төлөвлөсөн сургууль, мэргэжил

д/д	Байршил	Сургуулийн нэрс	Өмчлөлийн хэлбэр	Магадлан итгэмжлэгдсэн эсэх /1-тйим/	Мэргэжлийн чиглэл	Мэргэжлийн индекс	Мэргэжлийн нэр	Тухайн мэргэжлээр сурч буй 1-р ангийн оюутны тоо	Үүнээс: Судалгаанд хамрагдах оюутан
1	Да	Дархан коллеж	Хувийн		Боловсрол	D144801	Мэдээлэл зүй, англи хэл заах арга	50	10
2	Да	УГТСЭШХ	Төрийн	1	Бизнес удирдлага ба	D343475	Нягтлан бодох бүртгэл	78	20
3	Да	Дархан коллеж	Хувийн		Бизнес удирдлага ба	D343410	Бизнесийн эдийн засаг, удирдлага	38	10
4	Да	Дархан коллеж	Хувийн		Бизнес удирдлага ба	D343475	Нягтлан бодох бүртгэл	38	10
5	Да	Техникийн коллеж	Төрийн	1	Инженер техник	D520500	Дулааны эрчим хүч	20	10
6	Да	Техникийн коллеж	Төрийн	1	Инженер техник	D520401	Цахилгааны инженер	58	10
7	Да	Техникийн коллеж	Төрийн	1	Инженер техник	D520428	Уул уурхайн цахил-гаан хангамж, механик	39	10
8	Да	УГТСЭШХ	Төрийн	1	Хөдөө аж ахуй	D620125	Агро фермер	9	5
9	Да	УГТСЭШХ	Төрийн	1	Хөдөө аж ахуй	D620160	Агро хими хөрс судлал	7	5
10	Дд	Багшийн коллеж	Төрийн	1	Боловсрол	D140200	Багш, бага сургуулийн	58	20
11	Дд	Багшийн коллеж	Төрийн	1	Боловсрол	D144600	Математик заах арга	27	10
12	Дд	Багшийн коллеж	Төрийн	1	Боловсрол	D142220	Монгол хэл-уранзохиол заах арга	35	10
13	До	Анагаах ухааны коллеж	Төрийн	1	Анагаах ухаан	D720100	Эмчилгээ	85	30

Хавсралт 2 /үргэлжлэл/

д/д	Байршил	Сургуулийн нэрс	Өмчлөлийн хэлбэр	Магадлан итгэмжлэгдсэн эсэх /1-тийм/	Мэргэжлийн чиглэл	Мэргэжлийн индекс	Мэргэжлийн нэр	Тухайн мэргэжлээр сурч буй 1-р ангийн оюутны тоо	Үүнээс: Судалгаанд хамрагдах оюутан
14	Хо	Ховд дахь МУИС-ийн салбар	Төрийн	1	Боловсрол	D144601	Математик мэдээлэл зүй	32	10
15	Хо	Ховд дахь МУИС-ийн салбар	Төрийн	1	Боловсрол	D144602	Математик физик	23	10
16	Хо	Ховд дахь МУИС-ийн салбар	Төрийн	1	Боловсрол	D142220	Монгол хэл уран зохиол	27	10
17	Хо	Ховд дахь МУИС-ийн салбар	Төрийн	1	Боловсрол	D142211	Түүх нийгэм судлал	31	10
18	Хо	Ховд дахь МУИС-ийн салбар	Төрийн	1	Бизнес удирдлага ба	D343475	Нягтлан бодох бүртгэл	34	10
19	Хо	Ховд дахь МУИС-ийн салбар	Төрийн	1	Хууль эрх зүй	D380000	Эрхзүй	29	10
20	УБ	Боловсролын Их Сургууль	Төрийн	1	Боловсрол	D140200	Бага ангийн багш	226	40
21	УБ	Боловсролын Их Сургууль	Төрийн	1	Боловсрол	D144600	Математикийн багш	64	20
22	УБ	Боловсролын Их Сургууль	Төрийн	1	Боловсрол	D142220	Монгол хэл-уран зохиолын багш	39	20
23	УБ	Боловсролын Их Сургууль	Төрийн	1	Боловсрол	D142211	Түүх, нийгэм судлалын багш	32	20
24	УБ	Боловсролын Их Сургууль	Төрийн	1	Боловсрол	D144401	Физик-математик	30	20
25	УБ	Боловсролын Их Сургууль	Төрийн	1	Боловсрол	D144413	Хими-байгаль шинжлэл	33	20

Хавсралт 2 /үргэлжлэл/

д/д	Байршил	Сургуулийн нэрс	Өмчлөлийн хэлбэр	Магадлан итгэмжлэгдсэн эсэх /1-ТИЙМ/	Мэргэжлийн чиглэл	Мэргэжлийн индекс	Мэргэжлийн нэр	Тухайн мэргэжлээр сурч буй 1-р ангийн оюутны тоо	Үүнээс: Судалгаанд хамрагдах оюутан
26	УБ	Цагаан лавай багшийн дээд сургууль	Хувийн		Боловсрол	D142230	Багш, англи хэл	16	10
27	УБ	Цагаан лавай багшийн дээд сургууль	Хувийн		Боловсрол	D142220	Багш, монгол хэл-уран зохиол	13	10
28	УБ	МУИС-ийн Эдийн засгийн дээд сургууль	Төрийн	1	Бизнес удирдлага ба	D343468	Зах зээл судлал (маркетинг)	32	20
29	УБ	МУИС-ийн Эдийн засгийн дээд сургууль	Төрийн	1	Бизнес удирдлага ба	D343400	Менежментийн онол	50	40
30	УБ	МУИС-ийн Эдийн засгийн дээд сургууль	Төрийн	1	Бизнес удирдлага ба	D343475	Ня-бо бүртгэл	50	40
31	УБ	Санхүү эдийн засгийн дээд сургууль	Төрийн	1	Бизнес удирдлага ба	D343430	Банкны удирдлага	96	40
32	УБ	Санхүү эдийн засгийн дээд сургууль	Төрийн	1	Бизнес удирдлага ба	D340000	Бизнесийн менежмент	42	20
33	УБ	Санхүү эдийн засгийн дээд сургууль	Төрийн	1	Бизнес удирдлага ба	D343475	Нябо бүртгэл	98	40
34	УБ	Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль	Төрийн	1	Бизнес удирдлага ба	D343775	Нягтлан бодох бүртэгл	63	50
35	УБ	Монгол бизнес дээд сургууль	Хувийн	1	Бизнес удирдлага ба	D343410	Бизнесийн эдийн засаг, менежмент	140	75
36	УБ	Мандах-Бүртгэл дээд сургууль	Хувийн	1	Бизнес удирдлага ба	D343475	Ня-бо бүртгэл	89	30
37	УБ	Мандах-Бүртгэл дээд сургууль	Хувийн	1	Бизнес удирдлага ба	D343476	Нягтлан бодох бүртгэл хяналт шалгалт	120	45

Хавсралт 2 /үргэлжлэл/

д/д	Байршил	Сургуулийн нэрс	Өмчлөлийн хэлбэр	Магадлан итгэмжлэгдсэн өсөх /1-Тийм/	Мэргэжлийн чиглэл	Мэргэжлийн индекс	Мэргэжлийн нэр	Тухайн мэргэжлээр сурч буй 1-р ангийн оюутны тоо	Үүнээс: Судалгаанд хамрагдах оюутан
38	УБ	Хөдөлмөрийн дээд сургууль	Хувийн		Бизнес удирдлага ба	D343410	Бизнесийн эдийн засаг-Менежмент	33	20
39	УБ	Хөдөлмөрийн дээд сургууль	Хувийн		Бизнес удирдлага ба	D343230	Нягтлан бодох бүртгэл	51	30
40	УБ	Хүрээ коллеж	Хувийн		Бизнес удирдлага ба	D340116	Интернет бизнес	65	30
41	УБ	Хүрээ коллеж	Хувийн		Бизнес удирдлага ба	D343439	Мэдээллийн системийн удирдлага	56	20
42	УБ	МУИС-ийн Хууль зүйн дээд сургууль	Төрийн	1	Хууль эрх зүй	D380100	Олон улсын эрх зүй	29	10
43	УБ	МУИС-ийн Хууль зүйн дээд сургууль	Төрийн	1	Хууль эрх зүй	D380000	Хууль зүй судлал	122	30
44	УБ	Шихихутаг хууль зүйн дээд сургууль	Хувийн	1	Хууль эрх зүй	D380000	Хууль зүй судлал	143	50
45	УБ	МУИС Физик электроникийн сургууль	Төрийн	1	Байгалийн ухаан	D440104	Геофизик	17	10
46	УБ	МУИС Физик электроникийн сургууль	Төрийн	1	Байгалийн ухаан	D440125	Цаг уур	36	10
47	УБ	МУИС Физик электроникийн сургууль	Төрийн	1	Байгалийн ухаан	D440103	Физик цөмийн	23	10
48	УБ	МУИС Физик электроникийн сургууль	Төрийн	1	Байгалийн ухаан	D440113	Физик -экологи	30	10
49	УБ	МУИС Физик электроникийн сургууль	Төрийн	1	Байгалийн ухаан	D440109	Фикик Электроник	38	10

Хавсралт 2 /үргэлжлэл/

д/д	Байршил	Сургуулийн нэрс	Өмчлөлийн хэлбэр	Магадлан итгэмжлэгдсэн эсэх /1-Тийм/	Мэргэжлийн чиглэл	Мэргэж-лийн индекс	Мэргэжлийн нэр	Тухайн мэргэжлээр сурч буй ангийн оюутны тоо	Үүнээс: Судалгаанд хамрагдах оюутан
50	УБ	МУИС Химийн факультет	Төрийн	1	Байгалийн ухаан	D440208	Нефьтийн хими	13	5
51	УБ	МУИС Химийн факультет	Төрийн	1	Байгалийн ухаан	D440206	Хүнсний хими	21	15
52	УБ	МУИС Химийн факультет	Төрийн	1	Байгалийн ухаан	D440206	Химийн технологи	22	15
53	УБ	МУИС Химийн факультет	Төрийн	1	Байгалийн ухаан	D440205	Эрдэс хими	12	5
54	УБ	ШУТИС	Төрийн	1	Компьютер	D480105	Компьютерийн программ хангамж	80	50
55	УБ	Улаанбаатар дээд сургууль	Хувийн	1	Компьютер	D480105	Компьютерийн программ хангамж	84	25
56	УБ	Хүрээ коллеж	Хувийн		Компьютер	D480105	Компьютерийн программ хангамж	64	25
57	УБ	ШУТИС	Төрийн	1	Инженер техник	D520440	Автомашин ашиглалт, авто аж ахуй	48	20
58	УБ	ШУТИС	Төрийн	1	Инженер техник	D520446	Дотоод шаталтат хөдөлгүүрийн ашиглалт	30	20
59	УБ	ШУТИС	Төрийн	1	Инженер техник	D520302	Дулааны цахилгаан станц	47	20
60	УБ	ШУТИС	Төрийн	1	Инженер техник	D520604	Радио холбоо	29	20

Хавсралт 2 /үргэлжлэл/

д/д	Байршил	Сургуулийн нэрс	Өмчлөлийн хэлбэр	Магадлан итгэмжлэгдсэн эсэх /1-Тийм/	Мэргэжлийн чиглэл	Мэргэж-лийн индекс	Мэргэжлийн нэр	Тухайн мэргэжлээр сурч буй ангийн оюутны тоо	Үүнээс: Судалгаанд хамрагдах оюутан
61	УБ	ШУТИС	Төрийн	1	Инженер техник	D520303	Цахилгаан систем	57	20
62	УБ	ШУТИС	Төрийн	1	Инженер техник	D520404	Цахилгаан хангамж	35	20
63	УБ	ШУТИС	Төрийн	1	Инженер техник	D520601	Цахилгаан холбоо	38	20
64	УБ	ШУТИС	Төрийн	1	Инженер техник	D520300	Цахилгаан, электроникийн инженер	31	10
65	УБ	Газарчин дээд сургууль	Хувийн		Инженер техник	D520700	Инженер геологи	28	20
66	УБ	Хөдөө аж ахуйн их сургууль	Төрийн	1	Хөдөө аж ахуй	D620205	Газар зохион байгуулалт	111	10
67	УБ	Хөдөө аж ахуйн их сургууль	Төрийн	1	Хөдөө аж ахуй	D620130	Агрономи	29	10
68	УБ	Хөдөө аж ахуйн их сургууль	Төрийн	1	Хөдөө аж ахуй	D620201	Ойн инженер	29	10
69	УБ	Хөдөө аж ахуйн их сургууль	Төрийн	1	Хөдөө аж ахуй	D620600	Таваар судлал	64	10
70	УБ	Хөдөө аж ахуйн их сургууль	Төрийн	1	Хөдөө аж ахуй	D620131	Ургамал хамгааллын агрономи	54	10
71	УБ	ЭМШУИС	Төрийн	1	Анагаах ухаан	D720151	Эмч, нүүр амны	104	40
72	УБ	ЭМШУИС	Төрийн	1	Анагаах ухаан	D720100	Эмчилгээ	422	30
73	УБ	Ач анагаах ухааны коллеж	Хувийн		Анагаах ухаан	D720100	Эмчилгээ	101	50

Хавсралт 3

Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан оюутны тоо /суралцаж буй мэргэжлийн чиглэл, сургуулийн байршлаар/

	Мэргэжлийн чиглэл	Улаанбаатар	Дархан-Уул	Бусад /Ховд, Дорноговь, Дорнод/	Бүгд
14	Боловсрол	160		81	241
34	Бизнес ба удирдлага	448	42	10	500
38	Хууль эрх зүй	89		9	98
44	Байгалын ухаан	85			85
48	Компьютер	139	9		148
52	Инженер техник	166	31		197
62	Хөдөө аж ахуй	50	11		61
72	Анагаах ухаан	116		30	146
	Бүгд	1253	93	130	1476

Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан оюутны суралцаж буй мэргэжлийн чиглэл, их, дээд сургуулийн байршил /судалгаанд хамрагдсан нийт оюутны дотор эзлэх хувиар/

	Мэргэжлийн чиглэл	Улаанбаатар	Дархан-Уул	Бусад /Ховд, Дорноговь, Дорнод/	Бүгд
14	Боловсрол	10.8%		5.5%	16.3%
34	Бизнес ба удирдлага	30.4%	2.8%	0.7%	33.9%
38	Хууль эрх зүй	6.0%		0.6%	6.6%
44	Байгалын ухаан	5.8%			5.8%
48	Компьютер	9.4%	0.6%		10.0%
52	Инженер техник	11.2%	2.1%		13.3%
62	Хөдөө аж ахуй	3.4%	0.7%		4.1%
72	Анагаах ухаан	7.9%		2.0%	9.9%
	Бүгд	84.9%	6.3%	8.8%	100.0%

Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан оюутны хүйс ба их, дээд сургуульд суралцаж буй мэргэжлийн эрэлт хэрэгцээ

	Суралцаж буй мэргэжлийн эрэлт хэрэгцээ	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
1	Эрэлт ихтэй	329	547	876
	Тухайн хүйсийн дотор эзлэх хувь	58.6%	61.5%	60.4%
2	Дунд зэргийн эрэлттэй	176	214	390
	Тухайн хүйсийн дотор эзлэх хувь	31.4%	24.0%	26.9%
3	Эрэлт багатай	56	129	185
	Тухайн хүйсийн дотор эзлэх хувь	10.0%	14.5%	12.7%
4	Бүгд	561	890	1451
	Тухайн хүйсийн дотор эзлэх хувь	100.0%	100.0%	100.0%

Хавсралт 3 /үргэлжлэл/

Хүснэгт 9. ЕБС төгссөн газар ба их, дээд сургуульд суралцаж буй мэргэжлийн эрэлт хэрэгцээ /хувиар/

д/д	ЕБС төгссөн газар	Эрэлт ихтэй мэргэжил	Дунд зэргийн эрэлттэй мэргэжил	Эрэлт багатай мэргэжил	Бүгд
1	Улаанбаатар	48.9%	23.2%	18.4%	38.1%
2	Дархан	4.4%	5.1%	4.2%	4.5%
3	Эрдэнэт	4.4%	3.3%	8.9%	4.7%
4	Бусад аймаг, хот	30.9%	47.3%	37.4%	36.1%
5	Сум	11.5%	21.1%	31.1%	16.6%
	Бүгд	100.0%	100.0%	100.0%	100.0%

Хүснэгт 10. Төлбөртэй давтлага, дамжаанд хамрагдаж байсан оюутны тоо

д/д	ЕБС төгссөн газар	Давтлага/ дамжаанд хамрагдаж байсан	Давтлага/ дамжаанд хамрагдаж байгаагүй	Судалгаанд хамрагдсан оюутны тоо
1	Улаанбаатар	411	150	561
	Улаанбаатарт төгсөгчдийн дотор эзлэх хувь	73.3%	26.7%	100.0%
2	Дархан	43	24	67
	Дарханд төгсөгчдийн дотор эзлэх хувь	64.2%	35.8%	100.0%
3	Эрдэнэт	45	24	69
	Эрдэнэтэд төгсөгчдийн дотор эзлэх хувь	65.2%	34.8%	100.0%
4	Бусад аймгийн төв /Ховд, Дорнод, Дорноговь/	399	133	532
	Аймгийн төвд төгсөгчдийн дотор эзлэх хувь	75.0%	25.0%	100.0%
5	Хөдөөгийн сум	144	100	244
	Суманд төгсөгчдийн дотор эзлэх хувь	59.0%	41.0%	100.0%
	БҮГД	1042	431	1473
	Бүгдэд эзлэх хувь	70.7%	29.3%	100.0%

Хавсралт 3 /үргэлжлэл/

Хүснэгт 11. Төлбөртэй давтлага, дамжаанд хоёуланд нь хамрагдаж байсан оюутны тоо

